

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 71
1.	<i>Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10 – 69
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	69 – 71

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 06 дугаар сарын 18-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 56 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Д.Ганмаа, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Ж.Чинбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа.*

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаарт орсон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан сонсох асуудлыг нэг долоо хоногоор хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Идэрбат, С.Эрдэнэбат, О.Саранчулуун нар үг хэлэв.

Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Сангийн яамны Зарлагын хэлтсийн шинжээч В.Содномдаржаа, эдийн засагч Л.Батхуяг, хуульч Б.Төрболд, П.Баттулга, Б.Солонго, Б.Буянзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Үүрийнтуяа, Ц.Идэрбат, О.Саранчулуун, С.Зулпхар, М.Ганхүлэг, С.Эрдэнэбат, Ө.Шижир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Сангийн яамны Зарлагын хэлтсийн шинжээч В.Содномдаржаа, эдийн засагч Л.Батхуяг, хуульч Б.Солонго нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Түвшин, О.Саранчулуун, С.Зулпхар, Ж.Баясгалан, Х.Болормаа, Ө.Шижир, Л.Энхнасан нар үг хэлэв.

Л.Энхнасан: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Л.Энхнасан: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 92.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 32 минут үргэлжилж, 21 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 18-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
15 цаг 56 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Эрхэм гишүүдийн өдрийн мэндийг эрье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасны дагуу ирцийг сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулъя.

Хүрэлцэн ирсэн гишүүд Аюушийн Ариунзаяа 10 дугаар тойрог, Цэндийн Баатархүү 10 дугаар тойрог, Жадамбаагийн Баясгалан, Сархадын Зулпхар, 6 дугаар тойрог Цагаанхүүгийн Идэрбат, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Дашмягмарын Сарнай, Отгоны Саранчулуун, 2 дугаар тойрог Банзрагчийн Түвшин, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Өнөөдөр 8 дугаар тойрог Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн өвчтэй байна. Мөн 4 дүгээр тойргийн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн чөлөө авсан байна. 8 дугаар тойргийн Жигжидсүрэнгийн Чинбүрэн сайд засгийн хуралтай байна.

Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Хэлэлцэх эсэх.

Хоёрдугаарт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан.

Гуравдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Нэр дэвшигчийг сонголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай.

Эдгээр гурван асуудлыг ярина.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу?

Д.Үүрийнтуяа гишүүн. Микрофоныг нь өгнө үү?

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Маргааш чуулганы товд орсон учраас Нийгмийн даатгалын ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэх нь зүйтэй байх.

Хоёр дахь асуудал. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайлан хэлэлцэхэд салбарын сайд бас байх ёстой. Өнөөдөр ажлаа хүлээж авч байгаа. Салбарынхаа тайлантай танилцаж амжих, тэгээд эргээд гишүүдийн асуултад тэр асуудлаараа хариулт, мэдээллүүдийг өгч хамтарч ажиллахад бас хугацаа шаардлагатай болов уу гэж бодож байна.

Тийм учраас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайланг хэлэлцэх асуудлыг хойшлуулах санал гаргаж байна.

Л.Энхнасан: Тэгэхээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг нэг долоо хоногоор хойшлуулах саналаар санал хураалт явуулъя.

А.Ариунзаяа гишүүн саналаа хэлнэ үү.

А.Ариунзаяа: Төрийн байгуулал ямар ч улс төрийн үйл явц болж байсан бай төрийн албан хаагчдын ажлыг цалгардуулж ер нь болохгүй л дээ.

Одоо гадаа 20, 30 хүн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд.

Энэ бол зөвхөн сайд ч биш, олон хүн үйлдвэрчний эвлэлээс, ажил олгогчоос хуулиар үүрэг хүлээсэн маш олон хүн өдөр 2 цагаас хойш хүлээгээд сууж байна.

Нэг долоо хоногийн дотор сайд нь ажилтайгаа танилцаж төгс мэддэг болох нь ч хаашаа юм. Тэртээ тэргүй мэргэжлийн хүмүүс нь байгаа юм чинь тухайн Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагууд, яамны хүмүүс бүгдээрээ л ирсэн. Одоо хоёр, гурван цаг хүлээж байна.

Хууль зүйн бодлогын байнгын хороо 12.00 цагаас хуралдах ёстой байсан ч ирц нь хүрэхгүй 2 цагаас хуралдаж эхэлсэн.

Манай Байнгын хороо тэдний Байнгын хороог дуусахыг нь хүлээж нэлээд цаг алдаж, 2 цагаас хуралдах ёстой байсан. Одоо 4 цагаас өөр танхимд хуралдаж байна.

Тэгээд энэ төрийн албан хаагчдын ажлыг нь цалгардуулдаг байдлыг хүлээн зөвшөөрмөөргүй байна.

Нэгэнтээ олон хүн тайлангаа мэдэж байгаа, бэлдсэн байгаа юм чинь бид нар сонсоод мэргэжлийн хүмүүсээс нь уг нь асуулт, хариултыг нь аваад явбал их зүйтэй санагдаад байх юм.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, гишүүд ч гэсэн сая орохоос өмнө сонсвол яасан юм бэ, сонсуулах тал дээр нь санал гаргаад өгөөч ээ гэдэг хүсэлтийг гаргасан байгаа.

Тэгэхээр яах вэ санал хураагаад тэгээд шийдэж болно.

Л.Энхнасан: Санал хураагаад явъя.

А.Ариунзаяа: Төрийн албан хаагчдыг улс төрийн албан тушаалтнууд ингэж ажлыг нь цалгардуулдаг байх нь зохимжгүй юм гэдэг ийм саналтай байна.

Л.Энхнасан: Санал хураагаад явчихъя. Сайд өөрөө долоо хоногоор хойшлуулж өгөөрэй гэсэн хүсэлт өгсөн учраас ингээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг Д.Үүрийнтуяа гишүүний саналаар хураачихъя.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг нэг долоо хоногоор хойшлуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт хийе.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Хуруугаа дараад бэлдээрэй.

Сая бас 6 дугаар тойргийн Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Мөн 6 дугаар тойргийн Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүд ирсэн байна. Ирцэд бүртгээрэй.

Бэлэн үү? Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар дэмжигдлээ.

Тэгэхээр хоёрдугаар асуудал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан дараагийн долоо хоног болтол хойшлогдлоо.

Ц.Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Манай Байнгын хороодын бас нэг анхаарах ёстой нэг зүйл байна гэж үзэж байгаа.

Тэгээд үүнийг бас дараагийн Байнгын хорооны хурлаар оруулах, энэ долоо хоногийн хугацаанд бэлтгэлийг нь хангуулах зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа учраас үг хэлж байгаа юм.

Энэ бол нөгөө тэтгэврийн зээлийн нөхцөлийн асуудал байгаа. Энэ тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг ер нь нэлээн удаан ярилаа. Тодорхой хэмжээнд шийдвэр гаргах байгууллагын шийдвэрээ гаргах тэр хугацааг хүлээлээ.

Тэгээд энэ хүлээлт, бас гаргасан шийдвэр нь амьдралд төдийлөн нийцэхгүй, асар олон хүнийг бухимдуулсан ийм л шийдвэр байгаа.

Тэгээд энэ маань өөрөө анх гарахдаа л төрийн байгууллагаас эх үүсвэртэй учраас бид үүнийг засах тал дээр ер нь анхаарах ёстой юм байна.

Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороо тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр ер нь нэлээн нухацтай хандаж, ирэх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаан дээр хоёр үндсэн асуудлыг Монголбанкнаас тодруулах, танилцуулах ийм зүйлийг хийх ёстой гэж үзэж байгаа.

Нэгдүгээрт, тэтгэврийн зээлтэй холбоотой гаргасан шийдвэр яагаад ийм шийдвэр гаргах болов гэдгийг нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ банк, санхүүтэй холбоотой олон хууль тогтоомжууд гарч байгаа. Тэр дотроо банкны хүүг, тэр дундаа бүр хамгийн эрсдэлгүй гэж үзэж байгаа тэтгэврийн зээлийн хүүг буулгах энэ асуудал дээр ер нь Монголбанк ямар төлөвлөгөөтэй байгаа юм, юу төлөвлөж байгаа юм, хэзээнээс ямар үйл ажиллагаа явуулж эхлэх гэж байгаа юм бэ гэдэгт хоёр үндсэн сэдвээр би Монголбанкнаас мэдээлэл авах нь зүйтэй юм гэж үзэж байгаа.

Тэгээд тэтгэврийн зээлийг ярьж эхэлсэн цагаас хойш олон хүн. Хүний амьдрал баян юм. Тэгээд тэтгэврийн зээл гэдэг чинь үнэхээр нөгөө нэг дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу үед гол асуудлыг нь шийддэг ийм л зээл юм байна шүү дээ.

Тэгээд олон янзын л хүмүүс өдөр болгон хэдэн арваараа мессеж бичиж байна. Ялангуяа цэргийн тэтгэврийнхэн чинь надаас залуу хүмүүс тэнд тэтгэвэрт гарсан. Тэгээд ямар нэгэн бизнес хийхэд эх үүсвэр болгоё. Эрсдэлээ бид өөрсдөө хариуцъя. Тэгээд л эмнэлэг домолгод үзүүлмээр байна л гэнэ. Одоо нэг жоохон бизнесээ эргэлтийн зээл авмаар байна л гэнэ. Тэгээд үүнийг нь заавал 70:30, эсвэл 50:50.

Тэгээд гол хясаад байгаа юм нь энэ хугацаа байгаа байхгүй юу. Заавал нэг жил гээд. Тэгээд нэг жилийн хугацаанд авахаар тэр чинь аманд ч үгүй, хамарт ч үгүй нэг юм аваад л бизнес хийх ч хэцүү, байх ч хэцүү л юм руу ороод байна л даа.

Тэгэхээр энэ рүү ер нь нэлээн анхаарлаа хандуулж энэ хоёр асуудлаар би нэг ярих нь зүйтэй юм.

Тэгээд бидний энэ ярьж байгаа сэдэв бол нэг их тийм гийгүүлээд байхаар сэдэв биш шүү дээ. Яах вэ, 2026 оны Монгол Улсын төсөв дээр 6-аас 8 хувиар тэтгэвэр нэмэгдэнэ. Гэхдээ өнөөдрийн бидний энэ ярьж байгаа сэдэв бол энэ нэг жоохон бололцоогоо өөрсдөдөө ашиглаад амьдралын чанараа дээшлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, өөр олон ач холбогдолтой зүйлүүдэд нь заавал ингээд л хаагаад л.

Тэгээд арилжааны банкууд хугацааг нь заана гэдэг нэг юм тавьчихаад. Тэгээд арилжааны банкууд нь болохоор... /минут дуусав/

Л.Энхнасан: Зөв зөв. Тэгэхээр саяын хоёр тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг ирэх долоо хоногт ажиллана. Тийм.

Тэгээд ирэх долоо хоногийн тов дээр ажлын хэсэг бичээд авчихъя.

С.Эрдэнэбат гишүүн бас саналаа хэлж байна. Тийм.

С.Эрдэнэбат: Саяын үндэсний зөвлөлийн тайланг долоо хоногоор хойшлуулахад бас нэг яах вэ, хүндэтгэн үзэх шалтгаан. Та бүгд маань бас бодож үзүүлвэл.

Ирэх долоо хоног, яг долоо хоногийн дараа гэх юм бол манай энэ үндэсний зөвлөлд байж байгаа гишүүдийн, манай Үйлдвэрчний эвлэлийн холбооны их хурал болно.

Тийм учраас энэ тал дээр үндэсний зөвлөлийн гишүүд маань 4 жилд нэг удаа болдог хурал учраас нэг удаа энэ хугацааг нь хойшлуулах тал дээр та анхаарч өгөхийг хүсэж байна. Албан ёсны хүсэлт тавья гэж хэлсэн.

Хоёрдугаарт, сая Ц.Идэрбат гишүүний хэлдэг бол зөв өө. Бид нийгмийн даатгал дээр хураагдсан 700-аад тэрбумыг банканд үндэсний зөвлөл хадгалдаг.

Нөгөө талд нь тэтгэвэр олгох гэж байгаа зээлийг нь аваачаад Засгийн газар, Монголбанк хоёр бие бие рүүгээ чихээд дунд нь хаячихсан. Дунд нь яг ний нуугүй хэлэхэд та бүгд рүү ч гэсэн хандаж байгаа байх.

Нийгмийн бодлого үүнийг албан ёсоор яриад бас нэг талд нь байр сууриа тодорхой болгохгүй бол аягүй тийм сонин байдалтай байгаа учраас энэ

асуудлыг дараагийн хурал дээр Монголбанкнаас тодорхой мэдээлэл хүсэж авч ярья. Тодорхой шийдэл, чиглэл өгүүлэх тал дээр ажиллая гэж бодож байна.

Л.Энхнасан: Ойлголоо. О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Монголбанкттай уулзахтай холбоотой асуудал дээр Ц.Идэрбат гишүүний санал дээр нэмээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэвэр, группийн асуудалтай холбоотой, бас зээлтэй холбоотой асуудлууд байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр бас тодруулж, энэ уулзалтын сэдвийг, хамрах хүрээг өргөжүүлэх хүсэлтэй байна.

Л.Энхнасан: Ойлголоо. Ингээд өнөөдрийн хуралтай холбоотой өөр санал байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн
2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025 оны 05 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хийе.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсгийг оруулах уу? Б.Мөнхсоёл гишүүн ирсэн байна, Г.Уянгахишиг гишүүн орж ирсэн байна, Ж.Баярмаа гишүүн орж ирсэн байна, Х.Болормаа гишүүн орж ирж байна, Ч.Лодойсамбуу гишүүн бас орж ирсэн байна.

Хууль боловсруулахад ажилласан ажлын хэсгийг танилцуулъя.

Л.Батхуяг Эдийн засагч, Б.Төрболд хуульч, П.Баттулга хуульч, Б.Солонго хуульч, Б.Буянзаяа хуульч.

Сангийн яамнаас П.Бат-Эрдэнэ Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга. Засгийн хурал дээр байгаа юм байна. Одоо орж ирэх юм байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын төлөөллийг танилцуулъя.

Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, В.Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, А.Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын дарга.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин танилцуулна.

Б.Түвшин: Эрхэм Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүд Та бүхнийхээ энэ өдрийн мэндийг хүргэж, амрыг эрье.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд суудалтай 5 нам эвслийн төлөөлөл болсон бидний 41 гишүүн хамтран санаачиллаа.

Энэ хуулийн төслийг дараах асуудлуудыг нэг мөр зохицуулж, хүн, хуулийн этгээдийн ажил, бизнес, үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, ачааллыг бууруулах, ашиг орлого, өрсөлдөх чадвар, ажлын байрыг нэмэгдүүлэх, цаашлаад далд эдийн засгийг ил болгох, чөлөөт зах зээлийн харилцааг тэлэх, үүний үр дүнд татвар, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг үр дүн, бодит хэрэгцээ шаардлагыг харгалзан боловсруулсан. Үүнд:

▶ **Нэгдүгээрт**, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд хүнтэй иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулан ажиллаж ажил, үйлчилгээ эрхэлсэн хүнийг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчаас хасах. Эдгээр гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хасах.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2008 оны 05 сарын 08-ны өдөр батлагдсанаар өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлүүдэд заасан ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажилласан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг нийгмийн даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээлгэж, эдгээр гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогод хамруулж, гэрээ байгуулсан аль аль тал нь тухайн хувь хүнд хамаарах нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх үүрэгтэй болсон.

Үүгээр зогсохгүй 2023 онд батлагдсан нийгмийн даатгалын ерөнхий хуульд Иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ төдийгүй тэдгээртэй адилтгах гэрээ байгуулан ажиллаж буй хүнийг албан журмаар

даатгуулахаар нийгмийн даатгалын харилцааны хамрах хүрээг дахин өргөжүүлсэн.

Ийнхүү хуульд ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээнээс гадна тэдгээртэй адилтгах гэрээ гэж гэрээний төрлийг өргөн агуулгаар нь зааснаар иргэний хуулийн ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэлттэй холбогдсон үүрэгт хамаарах буюу ажил гүйцэтгэх, гэрээ хөлсөөр ажиллах гэрээтэй хамт нэг бүлэгт багтдаг нэрлэсэн болон нэрлэгдээгүй гэрээнүүд, тухайлбал, аялал жуулчлалын, тээвэрлэлтийн, хадгалалтын, даалгаврын, илгээмжийн, жуулчлалын гэх мэт олон төрлийн гэрээгээр гүйцэтгэх бизнес аж аж ахуйн шинжтэй бүх төрлийн харилцаанаас олсон орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах болсон байна.

Нөгөөтээгүүр Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу олсон орлого буюу татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээ гэх мэт бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил үйлчилгээний орлого, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох, хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэх, жуулчлалын үйл ажиллагаа, тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлого нь хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар үйл ажиллагааны орлогод хамаарч тухайн үйл ажиллагаа буюу бизнес эрхлэгч нь уг орлогыг үйл ажиллагааны орлогоор тайлагнаж, татвар төлөх зохицуулалттай.

Түүнчлэн эдгээр бизнес эрхлэгчид Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу жилийн 50 сая төгрөгийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээг бусдад борлуулснаар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болж, давхар татвар төлдгөөрөө хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж цалин хөлс авдаг ажилтнуудаас онцлог ялгаатайг Татварын хуулиудын эдгээр зохицуулалтууд харуулж байна.

Ийнхүү эрх зүйн зөрчил үүсгээд зогсохгүй хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээний дагуу олох орлогод ногдуулах нийгмийн даатгалын шимтгэлийг гэрээ байгуулсан, төлбөр шилжүүлсэн нийт дүнгээс шууд тооцож байна.

Хүнтэй байгуулах Иргэний хуулиар тодорхойлсон болон тодорхойлоогүй хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээний орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй болсноор ажил олгогч, ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд өөр гэрээ ашиглавал яах вэ гэдэг болгоомжлол байж болох юм.

Тэгвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэгт ажил олгогч ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 41.1.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно. Хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн

гэрээ байгуулсан боловч уг харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн шинжийг агуулсан бол түүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцно гэжээ.

Эндээс үзвэл Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах ажил олгогч, ажилтныг хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд хөдөлмөрийн гэрээнээс өөр буюу иргэний хуулийн аливаа гэрээ байгуулахыг хориглох ба хэдий өөрөөр нэрлэсэн ч хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжийг агуулсан байвал тухайн гэрээ нь хөдөлмөрийн гэрээнд тооцогдох байна.

▶ **Хоёрдугаарт**, ажил олгогчоос ажилтанд олгосон хоол, унаа, орон сууцын ашиглалтын төлбөр, түлээ, нүүрс худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлтийг цалин, түүнтэй адилтгах орлого болон нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хасах.

2008 оны 05 сарын 08-ны өдрийн нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар анх ажил олгогчоос ажилтанд олгосон хоол, унаа, орон сууцын ашиглалтын төлбөр, түлээ, нүүрс худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлтөд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж одоог хүртэл үйлчилж байна.

Ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дэмжлэг нь ажилтны өдөр тутмын наад захын хэрэгцээ, амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, тэдэнд тулгарч буй нийгмийн эрсдэл, санхүүгийн ачааллыг бууруулах, хөнгөвчлөх зорилготой байдаг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 хэсэгт цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ гэж заасан ба хоол, унааны төлбөр, түлээ, нүүрсний хөнгөлөлт, орон сууцын ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого нь ажилтны цалин хөлсний орлогод хамаардаггүй.

Иймд уг орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахаар зохицуулсан нь эдгээр төлбөр, хөнгөлөлтийг олгож буй үндсэн зорилготой нийцэхгүй байна.

▶ **Гуравдугаарт**, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин, хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг даатгуулагчийн адил тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тогтоох.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт нийгмийн даатгалын шимтгэлд төлөх, тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар заасан.

Энэ хязгаар нь даатгуулагч цөөн хэдэн сард хэт өндөр дүнгээр шимтгэл төлснөөр тогтмол цалинтай, нийгмийн даатгалын шимтгэлийг олон жил тасралтгүй төлж байгаа иргэдээс илүү өндөр тэтгэвэр тогтоолгох боломжийг хаах зорилготой.

Тэгвэл ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд хязгаар тавиагүй, тухайн даатгуулагчийн сарын нийт хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоор тогтоож байгаа нь даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээнд төдийлөн нөлөө үзүүлдэггүй бөгөөд ажил олгогч аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид ажилтны цалинг нэмэх боломжийг хязгаарладаг.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бодлогын өөрчлөлтийн нөлөөллийг зардал, үр өгөөжийн шинжилгээ буюу **COST**_[зардал] **BENEFIT**_[ашиг] **ANALYSIS** аргаар зардлын бага, дундаж, өндөр хувилбар бүхий гэсэн нөхцөлөөр тооцоход бүх хувилбарууд эерэг үр өгөөжтэй гарсан.

Хуулийн төсөл батлагдаж бодлогын өөрчлөлт гарсны нөлөөллийн үр дүнг өнөөгийн үнэ цэнээр тооцоход дунджаар 254.0 тэрбум төгрөгийн цэвэр үр өгөөжтэй байхаар байна.

Мөн 2025-2027 онд

- ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хассанаар 1508 ажлын байр,
- хоол, унаа, түлш, нүүрс, орон сууцын ашиглалтын зардлыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хассанаар 2479 ажлын байр,
- ажил олгогчийн хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээнд дээд хязгаар тогтоосноор 14 мянга 371 ажлын байр, нийтдээ 18358 ажлын байр нэмэгдэх тооцоолол гарсан.

Шинээр бий болох ажлын байрны өсөлттэй холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын орлогын өсөлт 2025-2027 онд дунджаар 242.1 тэрбум төгрөг байна.

Харин макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг **S-FAR** **/Structural-Fiscal Analytical-Redistribution/** загвараар тооцоход дотоодын нийт бүтээгдэхүүн

- эхний жилд 973 тэрбум,
 - хоёр дахь жилдээ 820 тэрбум,
-

• гурав дахь жилдээ 695 тэрбум төгрөг.

Нийт 3 жилийн туршид 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр тооцоолол гарч байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна.

1.Хүн, хуулийн этгээдийн бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, эдийн засаг, хууль зүйн дарамт, эрсдэл буурч, тэдгээрийн ашиг орлого, үйл ажиллагааны төрөл нэмэгдэнэ.

2.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх ачаалал буурснаар хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ажилтнуудынхаа цалин хөлсийг нэмэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөнгөвчлөх боломж нэмэгдэж, тэр хэрээрээ ажилтны ачаалал хөнгөрч, худалдан авах чадвар сайжирч, ашиг орлого, хэрэглээ өсөж, улсын эдийн засгийн эргэлт сайжирна.

3.Ажил олгогчийн зардал багассанаар ажлын байр нэмэгдэж хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсөж, ажилгүйдэл буурна.

4.Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зах зээл тэсэж үлдэх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

5.Бараа, ажил, үйлчилгээний нийгмийн даатгалын шимтгэлийн зардал буурснаар эцсийн хэрэглэгч дээр ирэх үнийн нэмэгдэл буурна.

6.Хууль хоорондын зөрчил арилна.

Эдгээр эерэг үр дагаврууд гарснаар Монгол Улсын эдийн засаг тэлж, далд эдийн засаг ил болоход нөлөөлж, тэр хэрээр эдийн засгийн эргэлт сайжирч, татварын суурь өргөжиж, нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Энэхүү хуулийн төслийг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр D-PARLIAMENT.MN цахим хуудаст байршуулсан.

Мөн иргэд, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлсэн бөгөөд хуулийн төслийг эсэргүүцсэн, дэмжээгүй санал гараагүй.

Хуулийн төслийг дэмжих олон нийтийн дэмжлэг маш өндөр байгааг дурдахыг хүсэж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Та бүхэн энэхүү хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж ирэхийг Та бүхнээсээ хичээнгүйлэн хүсэж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Б.Түвшин гишүүнд.

Одоо ингээд асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Үг тусдаа байгаа.

А.Ариунзаяа гишүүнээр тасалъя. А.Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

А.Ариунзаяа: 41 Улсын Их Хурлын гишүүнийхээ саналыг зарчмын хувьд хүндэтгэж байгаа. Зөв. Б.Түвшин гишүүн ч гэсэн өргөн барихаасаа өмнө сайдаар ажиллаж байсан хүний хувьд мэргэжлийн санал солилцох зэрэг ажлууд явагдсан.

Тэгээд эрсдэлүүд нь юу юм, давуу тал нь юу юм, юуг нь дэмжиж байгаа юм гэдгийгээ ярилцаад яг энэ хэлбэрээрээ орж ирж байгаа.

Нийгэмд бас нэг буруу ойлголт өгөгдсөнд миний хувьд харамсаж байгаа. Яагаад гэхээр яг энэ хууль өнөөдөр нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүмүүсийн шимтгэлийн хувь хэмжээ нь багасах юм шиг ийм ойлголтыг өгсөн. Ажил олгогчид ер нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй юм шиг ийм ойлголтыг өгсөн байгаа нь магадгүй нийгэмд алга ташилт аваад, яг яс юман дээрээ бол яг ийм нөхцөл байдал байхгүй.

Зөвхөн тэтгэврийн шимтгэлийг аваад үзэхээр тэтгэврийн шимтгэл ажил олгогч 8.5 хувь, ажилтан 8.5 хувь. Нийлээд аль аль нь 17 хувийг төлдөг. Үүнээсээ тэтгэвэр тогтоолгохдоо тухайн цалингийн 45 хувиар хамгийн багадаа цалин хөлснөөс нь бодогдож тэтгэвэр нь тооцогддог байгаа. Тийм ээ.

Тэгэхээр ажил олгогчийн төлж байгаа шимтгэл нь ямар ч бүртгэлгүй явагддаг. Төр зүгээр л өөртөө авдаг юм шиг ийм буруу олголтыг өгсөнд харамсаж байгаа.

Үүнийг ажлын хэсгийнхэн өөрсдөө залруулж нийгэмд хэлнэ биз дээ.

Яг энэ хуулийн төсөл бол яг өнөөдөр нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа иргэдийн хувьд шимтгэлийн хувь хэмжээ буурахгүй. Шимтгэл бодогдож байгаа цалин хөлснийх нь бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноороо ямар нөлөөтэй вэ гэдгийг бас сайн ярих хэрэгтэй.

Яагаад гэхээр өнөөдөртөө таны цалингаас жишээлбэл бага шимтгэл авч байгаа юм шиг санагдаж байгаа боловч ирээдүйд таны бодогдох тэтгэврийн хувь хэмжээ чинь буурч орж ирнэ шүү гэдгийг бас бид сайн хэлэх хэрэгтэй.

Яагаад гэхээр өнөөдөр миний 100 төгрөгөөс бодогддог байсан бол би алсдаа 100 төгрөгнөөсөө 45 хувь нь бодогдох бол би 80 төгрөгөөс бодуулаад ирэхээр 80 төгрөгийнхөө 45 хувиар л бодогдож орж ирнэ. Тийм үү?

Тэгэхээр энэ бол алсдаа миний, алсдаа ч биш өнөөдөр эрсдэлд орлоо гэхэд, листээ бодууллаа гэхэд тухайн бодогдож байгаа хэмжээнээс нь лист нь бодогдох учраас, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон бол тэтгэвэр, тэтгэмж нь бодогдох учраас энэ нь буурч орж ирнэ.

Ер нь хоёр хэлбэрийн бодолт байгаа. Тийм ээ.

- Нэг нь, хуримтлал суурьтай,
- Нэг нь, нэрийн данс суурьтай.

Тэгээд энэ хоёрын зааг дээр ямар ялгаа байгаа вэ, ямар нөлөөлөл үзүүлэх вэ гэдгийг Б.Түвшин гишүүн маань миний хугацаа дуусаж байгаа учраас та яг энэ дээрээ тайлбарлаад би эргүүлээд цаг авч 1 минутад дахиад асуулт асууя.

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн асуултдаа хариулна уу. С.Эрдэнэбат гишүүнийг бас нэмье.

Б.Түвшин: А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Юуны өмнө яг энэ хуулийн төсөл боловсруулагдаад 01 сарын 02-нд D-PARLIAMENT.MN дээр тавигдсаны дараа олон нийтэд нэлээн мэдээллүүдийг тал талаас түгээж явсан.

Энэ дээр зарим нэг ярилцлагаас болоод эндүүрэл гараад ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг огт төлөхгүй юм шиг ийм мэдээлэл тарсан.

Тэгэхээр энэ бол анхнаасаа ер нь тийм сэдэлгүй буюу D-PARLIAMENT.MN дээр тавихдаа **“ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын дээд хэмжээг нь тогтоох тухай”** гэж тавигдсан. Одоо ч тэр хэвээрээ байж байгаа.

Тэгэхээр энэ дээр буруу, зөрүү олон нийтэд мэдээлэл хүрсэн бол энэ дээр уучлалт хүсье.

Хоёрдугаарт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайд байсан олон мэргэжлийн хүмүүстэй энэ талаар уулзаж ярилцсан. Нэлээн зөвшилцөл хүрсэн. Ялангуяа гол гол мэргэжлийн сайд нартай уулзсан уулзалтууд энэ нийгмийн даатгалын нэмэлт, өөрчлөлтийн хуулийн агуулга, цаашдаа баримтлахдаа төдийлөн том зөрчил байхгүй юм гэдэг дээр бид санал нэгтэй нийлсэн гэж ойлгож байгаа.

Ер нь яг одоо цалин хөлснөөс тооцох нийгмийн даатгалын орлогын хэмжээг бид яаж, юунаас тооцох вэ гэдэг ийм суурь үзүүлэлтүүдийг тооцож байгаа.

2008 оноос өмнө бид яг Хөдөлмөрийн хуулийн дагуу тодорхойлж байсан цалин хөлснөөс тооцож байсан.

2008 оноос хойш иргэний хуулийн олон олон гэрээнүүдээс нийгмийн даатгал авч явдаг. Хувирсаар байгаад өнөөдөр бизнесийн орлогоос буюу иргэний хуулийн бүх төрлийн харилцаанаас нийгмийн даатгалыг хоёр талаас нь суутгаж авдаг ийм зохицуулалт руу орсон нь ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэгчид, байгууллагын хувьд ч гэсэн суутган төлөх дээр хүндрэл учирч байгаа учраас энэ харилцааг эрх зүйн хувьд бүрэн ангилъя гэж байгаа юм.

Энэ утгаараа ер нь цаашдаа бизнесийн орлого буюу иргэний хуулийн зохицуулалтын харилцаанаас нийгмийн даатгалыг хоёр талаас нь суутгахгүй байх зохицуулалт орж ирсэн.

Тэр унаа, хоол, байрны хөнгөлөлт гэдэг зүйл хуучин авдаггүй байсан. 2008 оноос нийгмийн даатгалын хууль дээр энэ хөнгөлөлтүүдээс нийгмийн даатгал авдаг болгохоор орж ирсэн.

Тэгэхээр энэ орж ирж байгаа асуудал хоёроос гурван талын өнцөгтэй харагдаж байгаа.

Нэг талдаа энэ хөнгөлөлтүүдийг авч байгаа яг ажилчдын бодит хэрэгцээ буюу гар дээр олгогдох мөнгө нэмэгдэнэ.

Нөгөө талаасаа буруугаар ашиглавал А.Ариунзаяа гишүүний хэлж байгаа шиг яг одоо нөгөө тэтгэвэрт тооцогдох суурь цалин багасаад, урт хугацаандаа бас тэтгэвэр тооцох орлого нь буурах ийм эрсдэл байгаа.

Тэгэхээр үүнийг тодорхой хэмжээнд

- итгэлцэл дээр,
- хэмжээ хязгаартай,
- яг зориулалтаар нь ашиглах ёстой байгаа юм.

Яагаад гэхээр хөдөлмөрийн хууль дээр тодорхойлсон “цалин хөлс” гэдэг тодорхойлолт нийгмийн даатгалын тухай хууль дээр тодорхойлсон “нийгмийн даатгалд ногдох цалин хөлс” гэдэг хоёр тодорхойлолт хоёулаа зөрүүтэй байгаа.

Хуулийн ийм зөрүүтэй байгаа учраас... /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулах уу?

Б.Түвшин: Тэгье. Хөдөлмөрийн хууль дээр заасан “цалин хөлс” гэдэг ойлголт цаашдаа ер нь албан журмын нийгмийн даатгалаа аваад явах нь зөв өө гэсэн үзэл баримтлал дээр одоо энэ хууль орж ирж байгаа.

Ер нь тэтгэврийг “хуримтлалын суурьтай”, “нэрийн дансны арга” гэсэн ийм хоёр аргаар тооцдог.

“Хуримтлалын суурьтай” гэдэг агуулга нь тэр дансан дээр нь мөнгө нь хуримтлагдаж явсаар байгаад ирээдүйдээ энэ нь тэтгэвэр тооцох суурь болно.

“Нэрийн дансны арга” гэдэг ч гэсэн бас л одоо энэ хуримтлалын хэлбэр буюу одоо бид нарын хэрэглэж байгаа.

Тэгээд энэ хоёр арга чинь 1979 оноос өмнөх, хойших гэсэн хоёр хүмүүст хуваагдана.

Тэгэхээр цаашдаа нийгмийн даатгал төлж байгаа чинь өөрөө хоёр давхар бүртгэл байгаа.

Нэг талдаа өнөөдөр нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлж байгаа, яг өнөөдөр зарцуулах мөнгөн санг бүрдүүлж байгаа, нөгөө талдаа ирээдүйд тэр төлж байгаа хүн ирээдүйд тэтгэвэрт гарах одоо тэр боломжийг нь хангаж өглөг болж бүртгэгдэж байгаа буюу давхар бүртгэлийн... /минут дуусав/

Л.Энхнасан: А.Ариунзаяа гишүүн тодруулна уу?

А.Ариунзаяа: Төр бол иргэнээ хэзээ ч хохирооё гэж шийдвэр гаргадаггүй. Хамгаалъя л гэж шийдвэр гаргадаг. Тийм ээ.

Тэгээд 2004 болон 2008 онд гаргасан энэ шийдвэрүүд нь юу байдаг вэ гэхээр тухайн ажилтантай нэг удаагийн хөдөлмөрийн гэрээ байгуулах байтал нэг удаагийн гэрээ байгуулаад нийгмийн даатгалын шимтгэл төлүүлэхгүй байх тал дээр нь зарим хүмүүс энэ цоорхойг ашиглаж, эргээд нөгөө ажилтан ямар нэгэн эрсдэлд орлоо гэхэд хөгжлийн бэрхшээлтэй байна уу, лист байна уу, декрет байна уу, бүхий л шимтгэлүүд төлөгдөөгүй юм чинь үйлчилгээ авдаггүй ийм цоорхой.

Хоёр дахь нь, цалин хөлсийг нь нэмэхгүй. Харин урамшуулал, нэмэлт хөлснүүдийг нь нэмснээрээ эргээд ажилтныг хохироох ийм явдлууд гарч байсан учраас энэ хуулиуд байсан юм.

Одоо энэ дээр зайлшгүй нөлөөллүүд орж ирнэ шүү.

Харин “хуримтлал” болон “цалин суурьтай” дээр. 9-хөн секунд үлдлээ. Одоо энэ дээрээ дахиад тайлбарлаад Б.Түвшин гишүүн яриад, дараа нь би дахиад тодруулъя.

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн хариулна уу.

Б.Түвшин: Ер нь тийм эрсдэлүүд байсан. Эдийн засгийн янз янзын тохиолдлууд, одоо татвар, нийгмийн даатгалаас зугтаах бодлогууд үе үеийн үед л байсаар ирсэн.

Бодлого боловсруулагчид бидний цаашдаа гаргаж тавих бодлого бол мэдээж нэг талаасаа энэ эрсдэлийг гаргуулахгүй байхаар хайх ёстой. Нөгөө талдаа хууль дээр байгаа зүйлийг итгэлцлийн хэлбэрээр, иргэн, аж ахуйн нэгжүүддээ цаашаа өсөж хөгжих, бодит зүйлийг нь бодитоор нь хийх тэр боломжийг олгох ёстой.

Тийм учраас энэ хөнгөлөлтүүдийг нийгмийн даатгалаас чөлөөлөх асуудал нь нэг талдаа яг тэр хөнгөлөлт гэдэг агуулгаараа итгэлцлийг төрүүлээд, одоо бодит орлогыг нь нэмэгдүүлж байгаа.

Нөгөө талдаа бас бизнес эрхлэгчдийг энэ тал руу хэтэрхий хазайх одоо бас тийм эрсдэлийг агуулж байгаа.

Нийгэм хөгжихийн хэрээр, аж ахуйн нэгж тогтворжихын хэрээр яг одоо энэ хөнгөлөлтүүд гэдэг агуулгаараа хэрэгжээд эхлэх юм бол энэ өөрөө одоо манай эдийн засагт нөлөөлөх үзүүлэлт нь бол нийгмийн даатгалын энэ санд авч байгаа, хуримтлуулж байгаа орлогоосоо хэд дахин илүү гэдэг ийм тооцоо гаргасан.

Л.Энхнасан: А.Ариунзаяа гишүүн тодруулах уу?

А.Ариунзаяа: Хуулиар 1960-аас 1979 оны хооронд төрсөн хүмүүс хоёр сонголттой. Эсвэл “нэрийн дансны буюу хуримтлал”, эсвэл “цалин суурьтай” бодуулах боломжтой. Тэтгэврийн.

“Цалин суурьтай” гэдэг маань өөрөө юу юм бэ гэхээр тухайн сүүлийн 5 жилийн дундаж гэж одоогийн хуулиар мөрдөгдөж байгаа. Тийм ээ. Түүнээсээ 45 хувиар тогтоогддог. Ингээд сонгож болох нь байна.

“Хуримтлал буюу юу нэрийн дансны аргаар” тэтгэвэр тогтооно гэдэг нь 1979 оноос хойш төрсөн хүмүүс ямар ч сонголтгүй, нэрийн данс буюу хуримтлал суурьтай тэтгэврээ тогтоолгоно. Энэ нь Та хэдий хэмжээний мөнгө төлсөн байна та болон таны ажил олгогч хэдий хэмжээний мөнгө төвлөрүүлсэн байна түүнээсээ цаашдын амьдрах магадлал. Тэр нь хэдэн жил, сараараа хуваагддаг юм байна. Түүндээ нийцсэн нэг сарын тэтгэвэр бодогддог байхгүй юу.

Тэгэхээр та цалин ч бай, хэдий хэмжээний шимтгэл бага төлнө төдий хэмжээгээр ирээдүйн тэтгэвэр чинь буурна, буурч орж ирнэ шүү.

Тэгэхээр энэ бол өнөөдөртөө ажил олгогчид ашигтай мэт боловч ирээдүйд ажилтан талаасаа бол эрсдэл үүсгэж байгаа бодитой ийм саналууд шүү гэдгийг хэлье.

Л.Энхнасан: Баярлалаа.

Ер нь энэ хуультай холбоотой нөгөө холбогдох яамдаас санал авсан уу? Саналууд ирсэн үү?

Ингээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Сангийн яамны төлөөллөөс саналуудыг нь сонсьё.

Л.Мөнхзул дарга Төрийн нарийн бичгийн дарга. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Л.Энхнасан даргын асуултад хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул.

Хуулийн төсөл нэгдүгээрт санхүүгийн үр дагавар нэлээд өндөр. Бодит зардлаар аваад үзэх юм бол үндсэн 3 зохицуулалт бүхий хуулийн төсөл байгаа.

► **Нэгдүгээрт**, ажил олгогчид ч болон даатгуулагчийн төлж байгаа шимтгэлийн хэмжээн дээр ижил хэмжээний хязгаар тогтоох. Үүнийг манай яамнаас зарчмын хувьд дэмжиж байгаа. Одоогийн хууль эрх зүй энэ чиглэлээр батлагдсан боловч санхүүгийн үр дагавраас болоод биелүүлж чадахгүй байсан.

Тэгэхээр энэ заалтыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн дүнгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний хязгаарыг тогтоохыг зарчмын зүйтэй. Энэ чиглэлээр ажиллах нь зүйтэй гэдэгтэй гишүүний өргөн барьсан хуультай санал нэгдэж байгаа.

Тэгээд мөн тус яамнаас боловсруулсан хуулийн төсөл дээр энэ заалтыг агуулгын хувьд оруулж ирэхээр төлөвлөж ажиллаж байгаа.

► **Хоёрдугаарт**, хоол унаа, орон сууцын ашиглалтын төлбөрийг 2004 оноос хойш мөнгийг байнга авч явж байгаа.

Тэгэхээр цалин хөлсний бүрэлдэхүүнд олон улсын жишгийн дагуу ерөөсөө “үндсэн цалин”, “нэмэгдэл урамшуулал” ордог.

Хоол унаа болон энэ бусад зардлууд үндсэндээ бусад орнуудад тэр болгон өгөөд байдаггүй. Манайх цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулаад явдаг.

Хэрвээ нэг ажилтны хоол, унааны зардлыг өдөрт 20 мянган төгрөгөөр тооцох юм бол шимтгэл төлөгч 844 мянган даатгуулагчид 20 мянган төгрөгийг нь хөнгөлөөд тооцно гэж өдрийнхөөр тооцохоор нийгмийн даатгалын сан дээр 891 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого буурах тооцоололтой байгаа.

Энэ хэрээр тэтгэврийн зарлагыг бууруулах уу гэдэг ийм асуудалд санхүүгийн үр дагавар байж байгаа.

Нөгөө талаасаа эрсдэл нь гэвэл энд хязгаар зааж өгөхгүй бол нийт цалин хөлсний бүрэлдэхүүнийг үндсэн цалингаа бууруулаад хоол унааны мөнгө хэлбэрээр олгох зохицуулалтыг бас ингэж жишиг гаргах ч юм уу, илүү зохицуулалтыг нарийсгах шаардлага байгаа.

Тэгээд хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн тохиолдолд уг заалтыг илүү нарийвчилж, магадгүй хамгийн доод хэмжээний хязгаар зааж өгөх ийм хувилбарууд бас байж болох болов уу гэсэн байгаа. Эдийн засгийн үр дагаврын хувьд байгаа.

► **Гуравдугаарт**, ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх үү гээд.

Монгол Улсын хувьд эдийн засгийн нөхцөл байдал улирлын шинж чанартай эдийн засгийн салбарууд маш өргөн байдаг.

Тэгэхээр улирлын шинж чанартай эдийн засгийн салбарууд дээр хөдөлмөрийн гэрээнээс татгалзаж, **“АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ”** болон **“ХӨЛСӨӨР ГҮЙЦЭТГЭХ”** рүү зугтаах магадлал маш өндөр гарч ирнэ.

Энэ дээр “хөлсөөр гүйцэтгэх” болон “ажил гүйцэтгэх” гэрээнээс нийгмийн даатгалын шимтгэл авч байгаа мөнгөн дүн маань одоо 49.0 тэрбум л байгаа.

Тэгээд үндсэндээ өөрөөр хэлбэл нийт 5.8 их наяд төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж байгаагаас 49.0 тэрбум төгрөгийг эдгээр гэрээнд ногдуулж шимтгэл авсан байдаг.

Тэгэхээр энэ зүйл, заалт хэлэлцэхийг дэмжигдсэн тохиолдолд зүйл, заалтыг илүү тодорхой болгож зохицуулалт хийхгүй бол түрүүн А.Ариунзаяа гишүүний дурдсанчлан даатгуулагчийн хөдөлмөрлөх эрх ашигтай байх хэрэгтэй.

Дээрээс нь Иргэний хууль дээр “ажил гүйцэтгэх” болон “хөлсөөр ажиллах” гэрээний ялгааг төдийлөн зааж өгөөгүй байдаг.

Нэг нь, үр дүнтэй. Нөгөөдөх нь үр дүн шаарддаггүй.

Нөгөө талаас гэрээн дотор “хөдөлмөрийн хөлс”, “цалин хөлс”-ийг тусгах эсэх асуудал зохицуулалт байхгүй бүрхэг байгаа учраас энэ заалт орсон тохиолдолд Иргэний хууль дээр бас холбогдох өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй болов уу гэсэн ийм зарчмын саналуудыг манай яамнаас гаргасан.

Л.Энхнасан: Сангийн яамны төлөөлөл арай орж ирээгүй байна.

Тэгэхээр Д.Үүрийнтуяа гишүүн асуултаа асууна уу?

Д.Үүрийнтуяа: Ажлын хэсгийн гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр 41 гишүүний хамтраад өргөн барьж байгаа Б.Түвшин гишүүний санаачилсан хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа.

Ер нь бид хууль эрх зүйн зөрчил үүсээд байгаа энэ зөрчлийг нэгдүгээрт арилгаж байгаа.

Үндсэн 3 өөрчлөлтийг 5 зүйлээр оруулж зохицуулж байгаа гэж харж байгаа.

Тэгээд сая миний асуух асуулт манай Л.Энхнасан дарга яамнаас тодруулаад хэллээ. Яам ямар байр суурьтай байгаа юм бэ гэж.

Хэлэлцэх явцдаа жижиг зарчмын асуудлууд дээр саналаа тохироод явах боломжтой юм. Ялангуяа тэр түлш, унаа, хоолны хөнгөлөлтийн хязгаарыг тогтоогоод явахад болохгүй юм байхгүй.

Энэ дээр мэдээж бид өмнө нь гарсан практик туршлага юмнууд байна. Үүндээ үндэслээд тогтоож болох байх гэж харж байгаа.

Надад байгаа ямар асуулт байна гэхээр Засгийн газрын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцээд дэмжээгүй гэж байгаа. Өчигдөр чуулган дээр би бас энэ байр сууриа илэрхийлсэн.

Тэгээд дэмжээгүй байгаа шалтгаан нь магадгүй одоо энэ хуулийн төслийг яам, салбарын яам өргөн барих гэж байгаа юм гэдэг асуудлууд яригдаад хэд хэдэн хуулийн төсөл дээр Засгийн газар дэмжээгүй санал ирүүлсэн байдаг.

Цаашид бид энэ гишүүдийн санаачлаад өргөн барьж байгаа хуулийн төслийг Засгийн газрын санаачилж байгаа хуультай агуулга үзэл баримтлалын хувьд давхардаж байгаа үед аль аль нь хэлэлцэж авч яваад, Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад нэгтгэх боломж нь бий гэдгийг С.Бямбацогт сайд тодорхой хариулсан.

Тэгэхээр яаман дээр хийгдэж байгаа хуулийн төсөл дээр үзэл баримтлалын хувьд нэгтгэх ямар ажлууд ажлын хэсэг хийсэн бэ? Энэ зохицуулалтыг олж харсан уу?

Энд яг л тэр тодорхой 3 зорилгынхоо төлөө энэ хуулийн өөрчлөлтийг хийсэн байгаа.

Ер нь хуулийг бүхэлд нь агуулгаар нь аваад үзэх юм бол нийгмийн даатгалын тогтолцоо, удирдлагын тогтолцооны асуудлыг ер нь хөндөхгүй юм уу? Хөндөх тухай ярилцаагүй юу? Ажлын хэсэг дээр энэ асуудал яригдаагүй юу? Яагаад гэхээр удирдлагын тогтолцооны зардал маань өөрөө сангаас гарч байгаа.

Тэгээд сангийн орлого тодорхой хэмжээгээр энэ хуулийн үр дүнд буурах юм бол нөгөө талдаа хэмнэлт хийх тэр тогтолцооных нь хариуцлага, удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүний ач холбогдол байх ёстой юу, үгүй юу гэдэг дээр бас судалж үзсэн судалгаа тооцоо байна уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Ажлын хэсэг болон салбарын яам бас энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ? Өөрсдийн өргөн барьж байгаа хуультай хэрхэн нийцүүлэх талаар гэдэг дээр хоёр талаас хариулт авмаар байна.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 6 дугаар микрофон. Нэрээ хэлээд танилцуулаарай.

П.Баттулга: Хуульч П.Баттулга асуултад хариулъя.

Энэ хуулийн төсөл дээр нийгмийн даатгалын удирдлагын түвшинд нийгмийн даатгалын ерөнхий хуульд ямар нэмэлт, өөрчлөлт оруулах вэ гэдэг дээр анхнаасаа үзэл баримтлалд тусгагдаагүй.

Энэ чиглэлээр бас нэмэлт, өөрчлөлт оруулах нь хэтэрхий хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх. Энэ бол цаашлаад нийгмийн даатгалын, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бас бодлогын асуудал байдаг учраас зөвхөн одоо энэ бизнес эрхлэгчдэд дарамт учруулж байгаа, энэ Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ. Зөвхөн энэ хоёр гэрээг ярих нь учир дутагдалтай.

Дээр нь тэдгээртэй адилтгах гэрээ гэсэн энэ нэмэлт, өөрчлөлтийг нийгмийн даатгалын ерөнхий хуульд оруулсан байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд голчлон авч үзээд. Дээр нь хоол, унааны мөнгө. Тэгээд мөн ажил олгогчоос төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэлийн дээд хэмжээнд дээд хязгаар тогтоох гэсэн энэ 3 гол тодорхой нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд л хуулийн төслөө боловсруулъя гэдэг энэ хүрээнд бид ажилласан.

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн хариулна уу.

Б.Түвшин: Д.Үүрийнтуяа гишүүний хэлж байгаа нийгмийн даатгалын удирдлагын тогтолцооны асуудал бол яалт ч үгүй бас цаашдаа яригдах асуудал.

Одоо нийгмийн даатгалын хуулийн эхлээд хуулийн зөрчилтэй буюу гадаад хэсэг болох Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль хоёрын зөрчилдөөд байгаа хэсэг буюу тэр бусад гэрээнээс нийгмийн даатгал авах уу, авахгүй юу гэдгээ эхний ээлжид тодорхойлоод, дараа нь нийгмийн даатгалын хууль, хөдөлмөрийн хууль хоёрын цалин хөлсний асуудлынхаа зөрчилдөөнийг арилгаад, тэгээд байгууллагаас төлж байгаа буюу дээд хэмжээг нь тогтоогоод.

Одоо үүний дараа яг энэ нийгмийн даатгалын дотоод энэ цуглуулж байгаа мөнгө, удирдлагын тогтолцоо, хүртээмж, зөв шударга байдал руу орж ирэх нь зөв өө.

Тэгэхээр хамгийн түрүүнд энэ 3 асуудлыг эхэлж авч хэлэлцье. Үүний дараа процессын асуудал дээр буюу ялангуяа нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоо, шударга хуваарилалтын асуудал, энэ санг удирдах асуудлыг цаашдаа ярих нь зүйтэй.

Тэгээд энэ удаагийн хэлэлцүүлгээрээ гадна талын хуулийн зөрчилтэй 3 асуудлыг авч хэлэлцсэн байгаа.

Л.Энхнасан: Тэгэхээр сая Д.Үүрийнтуяа гишүүн асууж байна шүү дээ. Нөгөө засгаас нийгмийн даатгалын шинэчлэл хуулиуд орж ирж байгаа. Үүнийг засахдаа ярьж зөвшилцсөн үү, ажлын хэсэг ажилласан уу гээд. Тийм ээ.

Б.Түвшин гишүүн хариулна уу.

Б.Түвшин: Түрүүн дурдсанчлан нийгмийн хамгааллын сайд нар байсан хүмүүстэй бүгдтэй нь ажлын хэсэг багаараа уулзалт хийсэн.

Энэ 3 заалт болон засгаас бэлтгэж байгаа хуулийн үзэл баримтлалуудаа нийцүүлсэн. Энэ бол нэг тал талаасаа төдийлөн томоохон зарчмын зөрүүтэй саналууд аль аль талдаа байхгүй. Мэдээж тодорхой тодорхой горимын саналууд байгаа учраас хууль санаачлагчдын зүгээс 01 сарын 02-нд өргөн барьсан хуулиа явуулж байя.

Одоо Засгийн газар хуулиа өргөн бариач үгүй байна. Хэлэлцүүлэг, санал авч байна. Бүр том огт болохгүй юм гэсэн тийм санал гараагүй учраас үүнийг хэлэлцээд явах нь зүйтэй гэж үзэж байна.

Л.Энхнасан: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулга хийнэ үү.

Д.Үүрийнтуяа: Би яамнаас тодруулмаар байна.

Тэгэхээр яг энэ яамны Хуулийн яамнаас боловсруулж байгаа энэ хуулийн төсөл дээр тэр нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоотой холбоотой энэ орж байгаа өөрчлөлтүүдээс өөр өөрчлөлтүүд бэлтгэгдэж байгаа юу? Ямар хугацаанд өргөн барих вэ? Өргөн барих хугацаа тодорхой болсон зүйл байна уу? Судалгааных нь ажлууд дууссан юм уу? Боловсруулалтын түвшин ямар байгаа юм? Энэ талаар бас мэдээлэл өгчих.

Л.Энхнасан: Л.Мөнхзул Төрийн нарийн бичгийн дарга. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Засгийн газраас Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг өргөн барихтай холбогдолтойгоор гишүүний хуульд дэмжээгүй гэсэн саналыг өгөөгүй. Тус яамнаас.

Засгийн газраас өргөн барихаар тус яамнаас боловсруулж ажлын хэсэг гарсан. Ажлын хэсгийн хуулийн төсөлд энэ хоол, унааны ашиглалтын төлбөрөөс шимтгэл авахгүй гэсэн агуулга бүхий заалт давхардаж ороогүй. Энэ заалт ороогүй байгаа.

Удирдлагын тогтолцооны хувьд нийгмийн даатгалын сангаас үйл ажиллагааны зардал огт гардаггүй. Нийгмийн даатгалын ажилтнуудын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлдэг. Бусад төрийн албан хаагчдын адил.

Олон улсын жишгээр аваад үзвэл нийгмийн даатгалын сангийн олж байгаа орлогынхоо 2 орчим хувийг ер нь стандартаар үйл ажиллагааныхаа зардалд зарцуулдаг. Манай Монгол Улсын хувьд 0.5 хувь орчимтой байдаг.

Тэгэхээр үр ашгийн хувьд илүү үр ашигтай. Бүх сангуудын шимтгэлийг нэг доор цуглуулж аваад буцаад зар... /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. 2 дугаар микрофон. Тэгээд хуулиа хэзээ өргөн барих гэж байна? Бэлэн болсон уу? Тэрийг бас хариулъя.

Л.Мөнхзул: Процессын хувьд хуулийг өргөн барихтай холбогдолтой дагавар 4 судалгаа, холбогдох баримт бичгүүд бэлэн болсон байсан.

Тэгээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн. Дэмжсэн. Гэхдээ Засгийн газар өөрчлөгдсөнтэй холбогдуулаад буцаж дахин яамдаас санал авах. Хууль зүйн сайд болон өөрчлөгдсөн яамдаас санал дахин авах ийм хэрэгцээ шаардлага гарч ирсэн.

Тийм учраас яамдаас санал аваад, ингээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд бид ажиллахаар өнөөдрөөс эхлээд бэлтгэл хангаад ажиллаж байна.

Л.Энхнасан: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулга хийнэ үү?

Д.Үүрийнтуяа: Дэмжээгүй. Тэгвэл Засгийн газрын хурлаар энэ гишүүдийн саналыг оруулсан хуулийн төслийн саналыг дэмжээгүй шалтгаан нь юу юм? Дэмжээгүй гэвэл нэлээн ноцтой асуудал байх гээд байна шүү дээ. Давхардаагүй гэдэг шалтгаан биш юм бол. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, засгаас бэлдэж байгаа танай яамнаас оруулсан хуулийн төслийг Засгийн газрын хурлаар хэлэлцсэн юм бол яагаад дахиад бусад яамдаас одоо дахиад шинэ засаг хүртэл авах гэж байгаа юм. Нэгэнт хэлэлцсэн өмнөх шийдвэрээрээ явдаггүй юм уу?

Гуравдугаарт, та миний асуултыг буруу ойлгох шиг боллоо. Би нийгмийн даатгалын байцаагчдын цалин хөлсний зардал, нийгмийн даатгалын хэлтсийн, газрын асуудлыг яриагүй л дээ.

Нийгмийн даатгалын удирдлагын тогтолцооны асуудлыг би асуугаад байгаа юм.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, түүний ажлын алба, дээр нь хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус хороо, мэргэжлийн хороо, маргаан хянан шийдвэрлэх зөвлөл гээд баахан бүтцүүд байгаа шүү дээ. Түүнтэй холбоотой асуудлыг л тодруулсан юм.

Энэ дээр тодорхой нэмэлт мэдээлэл авъя.

Л.Энхнасан: Л.Мөнхзул дарга хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд

- “нийгмийн ажил олгогч”,
- “даатгуулагч”,
- “Засгийн газрын төлөөлөл” ордог. Орон тооны бус зөвлөл.

Тодорхой хэмжээний орон тооны бус учраас цалин хөлс төдийлөн авдаггүй.

Ажлын алба 11 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Улсын төсвөөс цалин хөлс санхүүжиж ажиллаж байгаа.

“Мэргэжлийн хороо” гэж орон тооны бус зөвлөлүүд бас ажиллаж байгаа. Энд тодорхой хэмжээний урамшуулал хуралдаж ажилласан цагаараа тооцуулж авна.

2025 оноос эхэлж байгуулагдаад ажиллаж байгаа. Үйл ажиллагааны зардлын яг нийт төсвийн дүнг манай Нийгмийн даатгалын ерөнхий газрын төсөв дээр сууж явдаг учраас Б.Батжаргал дарга дэлгэрэнгүй хариулах байх.

Мэргэжлийн хороо байгуулж байгаа нь ямар учиртай вэ гэхээр цаашдаа нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, өсгөн арвижуулахад мэргэжлийн шийдвэр гаргах, хараат бус дүгнэлт гаргах зорилгоор энэ асуудлууд орж ирж байгаа.

Яагаад дахин яамдаас санал авах болсон бэ гэхээр Улсын Их Хурал дээр өргөн баригдах тоо... /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Засгийн газраас хэлэлцсэн боловч Улсын Их Хурал дээр өргөн баригдах тов тогтоогдоогүй.

Ерөнхий сайд солигдоод сайдын өргөн барих эрх нь 06 сарын 03-ны өдрөөр дуусгавар болсонтой холбоотойгоор, Хууль зүйн сайд солигдсонтой холбоотой үзэл баримтлалыг дахин батлуулах процессын техникийн шаардлага гарсан гэж бид нарт Хуулийн хэлтсийнхнээс зөвлөмж өгч байгаа.

Тэгэхээр үүнийг Засгийн газрын хуралдаанаар дахин шийдвэрлэх байх гэж бодож байна.

Л.Энхнасан: Тэгэхээр цаг хугацааны хувьд хэзээ бэлэн болох юм?

Л.Мөнхзул: Би Засгийн газрын шууд өмнөөс хэлэх эрх бүхий албан тушаалтан биш учраас хуулийн төслийг бид Засгийн газрын хуулийн хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу, өгсөн зааврын дагуу хууль зүйн техникийн бүрэн байдлыг хангаад аль болох хурдан хугацаанд өргөн барихаар манай яам ажиллаж байгаа.

Л.Энхнасан: Мөн дэмжээгүй гэсэн шалтгаанаа хариулж өгнө үү.

Л.Мөнхзул: Дэмжээгүйн үндсэн шалтгаан юу вэ гэхээр нэгдүгээрт төсвийн жилийн дундуур төсөв нэмэгдэх, зарлага нэмэгдэх, орлого буурах хуульд орсон тохиолдолд заавал Сангийн сайд болон бусад зардлын асуудлыг зохицуулах ёстой.

Тэгэхээр энэ хууль маань доор хаяж хамгийн энгийн хувилбараар тооцоход 1 их наядын төсвийн үр дагавартай байгаа.

Тэгэхээр тэтгэврийн сангийн зарлага дээр нөлөөлөл учрах нэгдүгээр эрсдэлтэй.

Хоёрдугаарт, иргэний хууль дээр зохицуулалт оруулалгүйгээр шууд зааж, анх яамдаас ирүүлсэн санал авахаар ирүүлсэн хуулийн төсөл өргөн барьсан төслөөс өөр байсан.

Энэ хуулийн төслөөр шууд нийгмийн даатгалын баталгаа алдагдах, олон улсын хөдөлмөрийн байгууллагын баталсан нийгмийн хамгааллын доод хэм хэмжээ 102 дугаар конвенцтой нэгдэхгүй байсан учраас яамнаас тухайн үед дэмжих боломжгүй гэдэг ийм саналыг өгч байсан.

Тэгээд орлого буурсан тохиолдолд татварын орлогоор буюу мөн ажил олгогчийн төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар тэтгэврийн зарлагыг санхүүжүүлэх үү гэдэг ийм асуудал... /минут дуусав/

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн нэмж хариулах уу?

Б.Түвшин: Ер нь энэ хуулийн 3 заалт гурвуулаа батлагдсан тохиолдолд ямар санхүүгийн үр дагавар үзүүлэх вэ гэдэг тооцооллуудаа бид олон янзаар хийж үзсэн.

Энэ бол Нийгмийн даатгалын ерөнхий газраас авсан мэдээлэл. Нөгөө талдаа статистикаас авсан мэдээллүүд байж байгаа.

3 заалт гурвуулаа нийлээд 300 орчим тэрбум төгрөгийн үр дагавартай. Үүнийг нийгмийн даатгалын сангийн өсөлтийн хувийг тооцохоор жилд дунджаар сүүлийн 10 жилд 7-гоос 25 хувиар өсөж явж байгаа. Энэ өсөлтийн гуравны нэгд хүрэхгүй буюу нийгмийн даатгалын орлогод эзлэх хувь нь 7.8 хувь байгаа.

Нөгөө талаасаа санг бууруулж байгаа энэ дүн, мөнгө хаашаа явах вэ гэдгийг COST-BENEFIT ANALYSIS гээд олон улсад хэрэглэдэг бодлогын шийдвэр гаргахдаа ямар үр өгөөж өг гэдэг юм бэ гэдэг энэ анализаар хийж үзэхэд 3 заалт тус бүр дээр нь 3 жилээр тооцоод үзэхээр цэвэр... /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. Б.Түвшин гишүүн.

Б.Түвшин: Цэвэр өгөөж нь 3 жилийн дараа 271.3 тэрбум төгрөгийн цэвэр өгөөжтэй буюу буурч байгаа зардал, орлогоо илүү нөхөөд эдийн засагт илүү нөлөө үзүүлнэ.

Нөгөөтээгүүр 18 мянга 300 гаруй ажлын байрыг шинээр нэмэгдүүлэх юм гэсэн ийм тооцоо гарсан байгаа.

Нөгөө талаас **SVAR** /STRUCTURAL VECTOR AUTOREGRESSION/ гээд бодлогын анализ хийдэг аргачлалаар SIMULATION хийж үзэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийг

- ▶ 2025 онд **973.0** тэрбумаар нэмэгдүүлэх юм байна.
- ▶ 2026 онд **820.0** тэрбумаар нэмэгдүүлнэ.
- ▶ 2027 онд **695.0** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.

Энэ 3 жилийн хугацаанд 2.4 их наядаар дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх тооцоолол гарсан байгаа.

Тэгэхээр энэ бүх тооцоолол өөрөө бид нарын албан ёсоор авсан date statistics дээр суурилсан.

Харин ч хамгийн өндөр тооцогдож байгаа 2024 оны статистик дээр суурилж тооцоо гарсан байгаа шүү гэдгийг бас хэлье.

Л.Энхнасан: Нийгмийн даатгалын ерөнхий газраас тооцоолол хийсэн юм байна уу? Зөрөөд байна. Бид нарт ирсэн тоонууд нь арай өөр тоонууд байна.

Энэ дээр Б.Батжаргал дарга нэг хариулт өгнө үү? 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Л.Энхнасан даргын асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Б.Батжаргал.

Хуулийн төслийн 3 зүйл, заалт дээр Нийгмийн даатгалын ерөнхий газар тооцооллоо хийгээд бас гаргасан. Тэгээд яамны хийсэн тооцоолол хоёр адилхан.

Тэгээд 1.1 их наядын ачаалал ирэх тооцоолол байгаа. Гол ачаалал нь дундын хувилбараар. Тэгээд энэ дээр хамгийн багадаа.

Орлого талдаа бууралт өгнө гэдэг бол бид **PAYGO** /PAY-AS-YOU-GO/ буюу “эв санааны нэгдлийн зарчим”-ын хувьд хууль хэрэгжиж эхэлнэ гэж үзэх юм бол бид 7 сараас тэтгэврээ тавьж чадахгүй гэсэн үг. Тэтгэмжээ олгоход маш хүндрэлтэй болно.

Тэгэхээр энэ зарлагын бууралтыг бид нэг бол дотациар нөхнө.

Тэгэхээр дотаци гэдэг бол улсын төсвийн санхүүжилт буюу татвар төлөгчийн мөнгө орж ирнэ гэсэн ийм тооцоолол бид хийж яамандаа болон холбогдох хүмүүст танилцуулсан байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: Сангийн яамны нөгөө П.Бат-Эрдэнэ орж ирнэ. Орж ирэхээр нь лавлая. Тийм ээ.

Ц.Идэрбат гишүүн асуултаа асууна уу?

Ц.Идэрбат: Хуулийн төсөлтэй танилцсан. Яах вэ, 3 заалт байгаа.

Тэгээд 3 заалтын заримыг нь дэмжмээр, заримыг нь эргэлзмээр юмнууд ч бас байгаа л даа.

Тэгээд хууль санаачлагчийн зүгээс 300 тэрбум. Тэнд яамныхан 1.1 их наяд гээд ярихаар чинь энэ хоёрын хооронд чинь асар их зөрүү байна шүү дээ. Ийм их зөрүүтэй юмыг бид одоо ер нь яах ёстой вэ?

Яах вэ, агуулгын хувьд нийгмийн даатгалын шимтгэлийг бууруул гэдэг нийгмийн шахалт асар өндөр байгаа. Сая би ингээд л “тэтгэврийн хүү” ярьж байна. Одоо “цалингийн хүү”, “зээлийн хүү”. Бид ингээд бизнес эрхлэгчид иргэд, дээр очиж байгаа дарамтыг зайлшгүй бууруулахын төлөө явах нь зүйтэй гэж бодож байгаа. Зүйтэй гэж бодож байгаа.

Тэгээд үүнийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явсны ард 1.1 юм уу, 300 тэрбум юм уу гэдгийг бид маш сайн судлах ёстой болж байна л даа.

Эндээс би хууль санаачлагчдын зүгээс жишээ нь хөдөлмөрийн гэрээгээс нийгмийн даатгал авдаггүй байя, хоол унаанаас авдаггүй байя гээд. Энэ хоол унааг нь би сайн санаж байна. Нийгмийн даатгалын багц хуулийг батлах үеэр зугтах юм болоод явдаг.

Тийм учраас авахгүй бол болохгүй гээд тал талаас нь ярьж байгаад л хуучнаар нь явсан юм. Тийм ээ.

Тэгэхээр ер нь бид сонголтыг нь үлдээж болох уу? Ялангуяа сүүлийн 5 жилдээ нийгмийн даатгалын шимтгэл төлөөд явж байгаа хүн бол аль болох л ахиу төлж, аль болох л А.Ариунзаяа гишүүний ярьдаг шиг тэр хувилбар луу явдаг шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр нэг бол хаагаад, нэг бол нээх биш. Бас сонголтыг нь өгөөд явах хувилбар бас байж болох уу?

Тэгээд хууль санаачлагч нар энэ хууль санаачлагчийн ард ажилласан тэр хүмүүс ямар тооцооллоор 300 гэж гаргасан юм. Яам ямар тооцооллоор 1.1 гэж. Энэ чинь 800 тэрбум төгрөгийн зөрүү гэдэг чинь асар их мөнгө шүү дээ. Хэдүүлээ маш сайхан гээд баталдаг. 800 тэрбум чинь татвар төлөгчдөөс хүрээд ирнэ шүү дээ. Дотаци өгөх болно.

Тэгэхээр их зөв учрыг нь олж хэдүүлээ. Энэ нийгмийн даатгал гэдэг бол их эмзэг сэдэв юм билээ дээ. Ер нь бас яаж хөндөх вэ гэдэг нь.

Би зарчмын хувьд Их Хурлын гишүүд сая миний хэлдэг энэ “зээлийн хүү”, энэ “нийгмийн даатгал”, энэ “татварыг бууруулах” гээд аль болох иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дарамтыг багасгах тал дээр санаачилгатай ажиллах нь би зүйтэй.

Тийм учраас хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явах нь зөв гэж харж байгаа. Тэгээд түүн дээрээ юмаа нийлүүлье, судалгаагаа хийе гэсэн ийм тооцоо байна л даа.

Тэгэхээр энэ дээр Та хэд маань хоёр тоо хэлээд байгаа. Энэ чинь ямар байлдаж тоглож байгаа биш дээ. Энэ тооцоо хийж байгаа хүн, тэнд яаман дээр тооцоо хийж байгаа хүн хоёр талаасаа суугаад, тэр баг нь суугаад яг юун дээр бид алдаад байгаа юм, аль нь зөв болоод байгаа юм. Энэ чинь аль нэг нь... /минут дуусав/

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн түрүүн ажлын хэсэг ажилласан уу гэдэгтэй адилхан л юу байна. Тийм. Б.Түвшин гишүүн хариулна уу.

Б.Түвшин: Энэ тооцоо, бүх судалгааг бүгдийг нь албан ёсоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон статистикуудаас албан ёсоор авсан тооцооллууд дээр бүх тооцоолол хийгдсэн буюу 2024 оны хамгийн өндөр тоон дээр суурилагдсан байгаа.

Тэгэхээр энэ тоо, статистикийг манай 4, 5 дугаар микрофон дээр сууж байгаа хуульч, эдийн засагч хоёр яг үндсэн суурь авсан, тооцоо хийсэн тооцоонуудаа нэг тайлбарлахих даа.

Л.Энхнасан: 5 дугаар микрофон. Нэрээ хэлээд.

Л.Батхуяг: Л.Батхуяг эдийн засагч.

Сая Б.Түвшин гишүүний хэлсэнчлэн манайх 300 тэрбум гэдэг тооцооллыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн лавлагаа мэдээллүүд дээр үндэслээд хийсэн.

Түрүүн нийгмийн даатгалын газраас хэлэхдээ хоол, унааны мөнгө дээр 800 тэрбумын өсөлт гарна гэдэг юм хэлэх шиг болсон. Нэг хүний 20 мянган төгрөгөөр хоол, унааны мөнгө нэмэгдэх юм бол 800 тэрбум төгрөг нэмэгдэхээр байна гэдэг тиймэрхүү байдлаар тооцоо хийсэн юм шиг байна.

Манайх бол яг тодорхой нийлбэр өсөлтийн аргаар cost-benefit analysis болон загварчлалуудыг ашигласных нь дагуу хийсэн байгаа.

Зүгээр нэг огцом шокийн өсөлт нэг юмнаас нөгөө рүү шилжинэ гэдэг тэр өсөлтийг хийгээгүй. Зүгээр энэ хуулийн төсөл гарсан тохиолдолд ийм юм ярьж болзошгүй гэдэг шок оруулсан юм болов уу гэж би бодоод. Яамныхыг.

Л.Энхнасан: 4 дүгээр микрофон гүйцээж хариулна уу.

Б.Солонго: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Хуульч Б.Солонго Ц.Идэрбат гишүүний асуултад нэмж хариулахад хуулийн төсөл санаачлагчдын авсан мэдээлэл нь түрүүн хэлсэнчлэн яг нөгөө Үндэсний статистикийн хороо болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023, 2024, тэрнээс өмнөх онуудыг гээд ийм дата дээр суурилсан байгаа.

Суурилахдаа хоол, унааны мөнгө 2024 онд дангаараа хоол унаа, түлээ түлш, орон сууц ашиглалтын мөнгөний зардал нь 2024 онд 63 тэрбум төгрөг гэж байгаа юм.

Тэгээд хөдөлмөрийн бус гэрээний орлого нь болохоор 43.4 тэрбум байгаа. Хамгийн сүүлийн асуудлынх болохоор ажил олгогчийн таазан дээр болохоор 236 тэрбум гээд, нийтдээ 300 гаруй тэрбумын асуудал яг сүүлийн жилийн хувьд бол яг энэ дата дээр байгаад байгаа.

Сая Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэлэхдээ ер нь нийт нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, даатгуулагч 800 хэдэн мянган хүнийг 20 мянган төгрөгөөр өдөрт хоол... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 4 дүгээр микрофон.

Б.Солонго: Тэгж тооцох юм бол жилдээ 800 хэдэн тэрбум. Тэгээд нөгөө хоёр үзүүлэлттэйг нь нэмэхээр нийтдээ нэг аравны хэдэн их наяд гэдэг дүн гараад байх шиг байна.

Тэгэхээр яг ингэж тооцох юм бол энэ хоёр дүн зөрнө. Яг 2025 ондоо ийм байх юм байна гэдэг нөгөө өсөлтийн анализтай нь 2024 оноо харьцуулах юм бол нэг аравны хэдэн их наяд шууд дүнгээрээ гарахгүй байх гэж бодож байна. Энэ нь болохоор бас нэг өөр тоо гарсан байсан. Тийм ээ.

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн нэмж хариулна.

Б.Түвшин: Энэ тооцоолол дээр их сонин. Импактын асуудлыг би нэг тайлбарлая.

Ер нь бол за одоо хоол, унааны мөнгийг нийгмийн даатгалаас чөлөөллөө. Энэ бол зүгээр орлогын албан татвар 10 хувиа аваад явна гэж байна. Үүнийг муугаар нь бодвол бүх аж ахуйн нэгжүүд хоол, унааны мөнгө рүүгээ бүх цалингаа шилжүүлээд явчихна. Энэ аргаар тооцвол тэр зөв л байх. Эсвэл ямар нэгэн байдлаар.

Нөгөө талд нь ихэнх аж ахуйн нэгжүүд жинхэнэ хөнгөлөлт гэдэг утгаар нь энэ нийгмийн даатгал тооцохгүй учраас одоо та нарт хоолны мөнгө өгье, унааны мөнгийг нь шийдье, түлшний хөнгөлөлтүүдийг нь шийдье гэдэг энэ хоёр концепцуудыг бид ямар сэтгэлгээгээр тооцож байгаа вэ гэдгээсээ хамаарна.

Бид нарын тооцож байгаагаар энэ явж байгаа хоол, унааны хөнгөлөлт гэдэг юмнууд явдгаараа л явах байх. Энэ хоёр хоёр тийшээгээ явна.

Тэгэхээр хамгийн муу тооцоолол буюу одоо тэр бүгдээрээ зугтаана гэдэг ойлгоц бол эдийн засаг муу буюу жижиг дунд таарууханхан газар л... /минут дуусав/

Л.Энхнасан: Сангийн яамны төлөөлөл ирсэн байна. 8 дугаар микрофон. В.Содномдаржаа Сангийн яам хариулна уу.

Хуультай холбоотой тооцоонууд гарсан уу? Энэ тооцооллуудыг хийсэн үү? Энэ тал дээр?

В.Содномдаржаа: Сайн байна уу? Би Сангийн яамны Зарлагын хэлтсийн шинжээч В.Содномдаржаа.

Тэгээд хуулийн төсөлтэй холбоотойгоор ерөнхийдөө тооцоолол зүйлүүдийг манай яаман дээр хийсэн.

Нэг талаасаа хуулийн төсөл дээр туссан асуудлууд бол одоо иргэдэд ирж байгаа энэ нийгмийн даатгалын шимтгэлийн дарамтыг бууруулах сайн талтай хэдий ч яг өнөөгийн нөхцөл байдалд Нийгмийн даатгалын сан өөрөө Нийгмийн даатгалын ерөнхийхөө ерөнхий хууль дээр заасан санхүүгийн хувьд бие даасан, хараат бус байх тийм зарчмыг хэрэгжүүлж чадахгүй нөхцөл байдалд аль хэдийн хүрчхээд байгаа.

Тэрийг яагаад тэгж хэлж байна гэхээр Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль дээр... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 8 дугаар микрофон.

В.Содномдаржаа: Улсын төсвөөс 1 их наяд 452 тэрбум төгрөгийн шилжүүлэг авахаар байгаа.

Энд юу байна гэхээр яг хуулийн дагуу улсын төсвөөс олгохоор заасан шимтгэлийн зардлууд, улсын төсвөөс даахаар хуульчилсан “цэргийн тэтгэвэр” гэх мэтчилэн зардлууд байгаагаас гадна сангийн яг цэвэр алдагдалтай холбоотой 700 тэрбум төгрөгийг олгохоор байгаа.

Юу гэдэг юм. Цаашид ингээд нийгмийн даатгалын хуульд орлого буурах, зардал нэмэгдүүлэх ийм асуудлуудыг тусгаад явбал эргээд сангийн алдагдал маань тэр хэмжээгээрээ нэмэгдээд л явна.

Яг одоо байгаа хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн зардал жилд инфляцын түвшинтэй уялдуулаад 500-аас 600 тэрбум төгрөг зарлага нь цэвэр нэмэгдэхээр байгаа.

Түүнээс гадна хүний тооны өсөлттэй холбоотойгоор сангийн зарлагынхаа ойролцоогоор 3 орчим хувиар зардал нь зөвхөн нэг талдаа өсөхөөр. Гэтэл... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу.

В.Содномдаржаа: Орлогын өсөлтийг нь тооцох юм бол яг энэ зарлагын өсөлтийгөө гүйцэхүйц хэмжээнд зардлаа санхүүжүүлж чадахгүй хэмжээнд хүрсэн. Нэг талаасаа сан гэдэг талаасаа хүнд зайлшгүй зарим шинэчлэл зүйлүүдийг хийхээр болоод байгаа.

Тэгээд яг энэ үед нь ахиад орлого бууруулах гэдэг ч юм уу. Яах вэ нэг талаас зарчмын хувьд зөв зүйлүүд байгаа ч гэсэн орлого бууруулах иймэрхүү шийдвэрүүд нь эргээд яг сан гэдэг утгаараа ажиллахад бас хүндрэлтэй нөхцөл байдлыг улам л нэмэгдүүлэхээр байгаа.

Л.Энхнасан: Харин тийм. Л.Мөнхзул дарга хариулна. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: 1.1 их наяд төгрөгийг яаж гаргасан бэ гэдэг асуултад хариулъя.

Тэгэхээр яг энэ хоол унааны мөнгөтэй холбогдолтойгоор хөнгөлсөн тохиолдол 2026 онд 891 тэрбум төгрөгийн зардал дундаж хувилбараар тооцоход, хамгийн өөдрөг хувилбараар тооцоход 445 гээд, дундаж хувилбараар 668 тэрбум төгрөг зарцуулагдахаар байгаа.

Энэ бол маш тодорхой. Төрийн албан хаагчид жишээлбэл хоол, унааны мөнгө гэж нэг өдрийн 20-оос 25 мянган төгрөгөө авдаг.

Тэгэхээр 22 хоногоор үржүүллээ. Энэ дүн шимтгэлийн орлого чөлөөлөгдөнө өө л гэсэн үг.

Тэгэхээр цаашдаа хэрвээ ажил олгогч 15 мянган төгрөгөөр хоол өгсөн тохиолдолд 22 хоногоор үржүүллээ. Шимтгэлийн 20 хувийн ажил олгогч, даатгуулагч аль алинаас нь буурахаар байгаа. Ингээд шууд цэвэр дүн.

Тэгэхээр өөрөөр хэлбэл бид өнөөдөр нэг өдрийн хоол унааны зардал 15-аас 20 мянга гэж байгууллагуудад дунджаар олгодог ийм олон улсын жишиг байгаа.

Яамд бол ер нь 30 орчим... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Хөдөө орон нутаг, аймгийн төв болон сумын төв гээд байгууллагуудаасаа шалтгаалаад 3-аас 12 мянган төгрөг салбар болгон харилцан адилгүй төрийн албан хаагчдын хувьд гээд 226 мянга орчим төрийн албан хаагчдын хувьд шимтгэлийн орлого дунджаар 20 мянган төгрөгөөр хоолны зардалд тооцогдож байгаа.

Хувийн хэвшлийн хувьд харилцан адилгүй байгаа.

Тэгэхээр хот, хөдөөд хоолны зардлыг 15 мянган төгрөгөөр тооцоход 668.8 тэрбум төгрөг яг шимтгэлийн орлогод хасагдах ийм төлөвлөгөөтэй байгаа.

Тэгээд яах вэ манай байгууллагуудаас мэдээллээ өгөхдөө цалин хөлсний орлогын бүрэлдэхүүнийг ажлын хэсэгт нийгмийн даатгалын байгууллага өгөөгүй байж болзошгүй. Тийм. Тэгээд энэ мэдээллүүдээ бас... /минут дуусав/

Л.Энхнасан: Ц.Идэрбат гишүүн тодруулна уу?

Ц.Идэрбат: Тийм. Яах вэ, тэгээд нэг л тоон дээр хоёр талаасаа яриад л ийм их зөрүү гаргачхаад сууж л байгаа юм байна л даа. Яг л нэг тоо байгаа шүү дээ. Тийм.

Тэгэхээр бид энэ дээр тэгнэ ингэнэ гэхээсээ илүү тооцоо, энэ чинь тоо л биднийг чиглүүлнэ шүү дээ.

Зарчим бол ер нь бууруулах талдаа байх нь зүйтэй л гэсэн ийм л юм байгаа юм.

Миний дараагийн нэг сонирхоод байгаа юм яг энэ Нийгмийн даатгалын хуультай холбоотой холбоотой энэ чинь Засгийн газраас газраас нэг хууль хууль өргөн барих гээд. Сая та хэллээ. Тийм ээ. Түүн дээр яг энэ зүйл, заалтууд ер нь орсон юм уу?

Хэрвээ тэр хуулийн төсөл дээр энэ нийгмийн даатгалын шимтгэлийн дарамтыг ямар нэгэн хэмжээгээр бууруулах гэдэг юм уу. Тийм ээ. Тэр даатгуулагчийн эрх ашгийг хангасан тийм ямар зүйл, заалтууд бас түүнд тусгагдаад явж байгаа юм.

Тэгээд одоо энэ Хууль зүйн яамнаас үзэл баримтлал дээр нь бас санал авах юм байна шүү дээ. Тэгж ойлголоо.

Тэгэхээр энэ хоёр хуулийн хувьд ямархуу зөрүүтэй агуулгууд түүн дотор байгаа юм. Ижил юм байгаа юм уу?

Л.Энхнасан: Л.Мөнхзул дарга хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Засгийн газрын газраас өргөн барьсан нийгмийн даатгалын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтөд шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх агуулга байхгүй. Аль болох ажил олгогч, даатгуулагчид ногдуулж байгаа. Ялангуяа ажил олгогчид ногдож байгаа нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулахыг үндсэн зорилго болгож байгаа.

Гэхдээ ажил олгогчийн шимтгэлийг нэг талыг хэт бууруулснаар тэтгэвэрт гарахад бэлдсэн болон тэтгэвэрт гарахаар хүлээж байгаа олон жил хийсэн даатгуулагчийн авах тэтгэврийн хэмжээнд бууралт буюу сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар мэргэжлийн техник үзүүлэлтүүдийг оруулж байгаа.

Хэрвээ бид энэ хуулийг батлах, хоол, унаанаас зардал авахгүй гэхэд төрийн албан хаагчийн хувьд 30 мянган төгрөгөөр жишээлбэл яамны нэг албан хаагч 30 хоног гэж бодоход 900 мянган төгрөгийн цалингийн бүрэлдэхүүнээс хасагдана.

Тэгэхээр тэр хүний өөрөөр хэлбэл тэтгэвэр бодох цалингийн тэр дундаж дүн огцом буурна гэсэн үг. Тэгээд ийм нөлөөллүүд байгаа учраас энэ тооцооллыг ажлын хэсгийнхэнтэйгээ манай яамнаас давхар сууж ажиллах бололцоотой.

Засгийн газраас өргөн барьсан хуулийн үзэл баримтлалын хувьд ажил олгогчид ногдох шимтгэл... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээгээд хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Засгийн газраас өргөн барихаар төлөвлөсөн хууль дээр ажил олгогчид ногдох шимтгэлийн ачааллыг аль болохоор бууруулах чиглэл баримтлах бас тийм үзэл баримтлал байгаа учраас хоёр хууль Улсын Их Хурлаас хэлэлцэхээр дэмжигдсэн тохиолдолд тухайн үед нь энэ зөрүүтэй зохицуулалтын заалтуудыг бас нэгтгэсэн байдлаар авч үзэх хувилбар байж болох байх гэж үзэж байна.

Л.Энхнасан: Ц.Идэрбат гишүүн дахиад тодруулга.

Ц.Идэрбат: Тийм. Яах вэ, хуулийн төслүүд дээр ажилласан багийнхан хоёр талаасаа тооцоо юман дээрээ нэлээн маш сайн суухгүй бол бид энд ингээд дэмжих шиг амархан юм байхгүй шүү дээ.

Гэхдээ бидэнд бас нэг гашуун түүхүүд байгаа. Жишээ нь, одоо хүртэл шийдэгдээгүй асуудал. Нөгөө малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал. Даана гээд хэлсэн. Хууль гаргасан, бүр. Тэгээд даах гэхээр сан нь даахгүй. Тэгээд малчдын өмнө очоод хууль чинь гарсан. Өнөөхөө яав гэхээр үгүй одоо тэгээд тоо л одоо эцсийн дүндээ үнэнийг л хэлнэ шүү дээ.

Тэгээд л одоо ингээд боломжгүй байна, журам нь гараагүй байна гээд л аргалаад л худлаа яриад л яваад байгаа шүү дээ. Ер нь яг үнэндээ бол. Тийм.

Тэгэхээр аливаа шийдвэр гарахдаа эрх зүйн үр дагавар, ялангуяа төсөв мөнгөтэй холбоотой асуудал дээр бид их нухацтай хандах ёстой байгаа юм.

Тэгэхээр яам нь ч тэр, нэг нь 1.1, нэг нь 300 гэж ярьж байгаа энэ их зөрүүг л одоо би жоохон эмхлэх л хэрэгтэй юм байна даа л гэж миний хувьд бодогдлоо шүү. Ер нь бол эндээс. Тийм. Баярлалаа.

Л.Энхнасан: О.Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Эхлээд эхлээд би нэг хэдэн тоо асууя гэж бодож байгаа. Ажлын хэсгээс.

Нийгмийн даатгалын шимтгэлийг 5 жил буюу 36 сар төлөөд халамжаасаа Нийгмийн даатгал руу шилжсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог эхлээд сонсох хэрэгтэй байгаа. Нэгдүгээр асуудал нь.

Хоёрдугаар асуудал нь, өнөөдрийн байдлаар хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоосон хөгжлийн бэрхшээлтэй хүн хэд байна вэ гэдэг мэдээлэл байгаа. Би энэ дээр жин харах гээд байгаа.

Гуравдугаарт нь, ажилгүйдлийн тэтгэмж бол угаасаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олддоггүй юм. Давхацдаг гээд байдаг учраас. Тэгэхдээ өнөөдрийн ажил хайж байгаа хүмүүсийн хэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байна вэ гэдгийг бас мэдмээр байгаа. Нэг тийм та нарт баримжаа байх ёстой байх. Энэ мэргэжлийн хүмүүс ирсэн учраас.

Банк, санхүүгийн үйлчилгээнд нийгмийн даатгал төлөөд байгаа мөртлөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үнэхээр боломж олддоггүй юм.

Тэгэхээр ер нь банк, санхүүгийн цалингийн зээл ч тэр, ипотек ч тэр, ер нь хувь хүний санхүүгийн эрх зүйн чадамжийг үргэлж хязгаарлаад байгаа нэг ийм асуудал байгаа. Сангийн яам бас байгаа юм байна.

Тэгэхээр өнөөдрийн байдлаар энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст цалингийн зээл авсан хүмүүсийн хэд нь хөгжлийн бэрхшээлтэй юм, ипотекийн зээлд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүн хамрагдсан юм бэ гэдэг ийм 4 тоог

барагцаалаад ч болов надад нэг хэлээч. Түүний дараа дахиад би тодруулж ярих юмнууд байгаа. Минутаа хадгалж байгаад.

Л.Энхнасан: түрүүлээд Сангийн яамнаас хариулах уу? 8 дугаар микрофон.

В.Содномдаржаа: Гишүүний асуултад хариулъя.

Яг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл яг илүү нарийн тоо Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гарах байх.

Ипотекийн зээлийн тухайд яг одоо миний бэлдэж ирсэн материал дээр яг үүнтэй холбоотой мэдээлэл байхгүй байгаа учраас нарийн тоо хэлж чадахгүй байна. Уучлаарай.

Л.Энхнасан: Л.Мөнхзул дарга хариулах уу? 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд ихэвчлэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авдаг. Нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг.

2024 оноос өмнө үйлчилж байсан хууль дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3 жил хөгжлийн бэрхшээлтэй болсноос шимтгэл төлсөн тохиолдолд гээд Нийгмийн даатгалын сан руу шилжиж болдог байсан. Жил ороод нэлээд тооны хүмүүс шилждэг байсан. Тэгээд энэ зохицуулалт 2024 оны хуулиар өөрчлөгдсөн.

Дэлгэрэнгүй тоон мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас хариулна.

Ажил хайж байгаа нийт ажил хайгчдын дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо харьцангуй цөөхөн байдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хайхгүй байна гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл ажил хайх гээд очихоор тохирох ажлын байр бага байдаг. Тохируулгатай ажлын байр хүндрэлтэй байдаг.

Ийм учраас яалт ч үгүй төрөөс дэмжлэг хэрэгтэй. Ийм учраас хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулсан тохиолдолд 12 сарын хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээгээд хариулна уу. 1 дүгээр микрофон Б.Батжаргал дарга.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя.

2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад хүүхдийн тоог оруулахгүйгээр хөдөлмөрийн чадвараа алдсан хүний тоо 101 мянга 612 байгаа. Энэ 101 мянга 612 хүнээс Нийгмийн даатгалын сангаас яг бүрэн тэтгэвэр авдаг ангилалд 39 мянга 486 хүн бүрэн тэтгэвэр авдаг. Доод хэмжээ нь арай өөр байдаг. 17 мянга 723 хүн хувь тэнцүүлсэн тэтгэвэр буюу одоо нөгөө цөөн жилтэй гэсэн ангиллаар тэтгэвэр авдаг. Нийтдээ ингээд 57 мянга 209 хүн Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр аваад, үлдсэн хүмүүс нь нөгөө нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил байхгүй учраас Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авдаг ийм тоо баримтууд байна. Баярлалаа.

Л.Энхнасан: О.Саранчулуун гишүүн тодруулж асууна уу?

О.Саранчулуун: Би яагаад энэ 4 тоог асууж байгаа гэхээр угаасаа дандаа л тоогоо гаргахгүй байгаа учраас энэ асуудлыг бас дүгнэлт хийж болохгүй байна л даа. Би одоо жишээлбэл дүгнэлт хийх гэхээр тоогүй болчихоод байна. Тийм ээ.

Нийгмийн даатгалын сангаас олгогддог үндсэн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнүүдийн хэдэн хувь хэрэглэгч нь хөгжлийн бэрхшээлтэй байна вэ гэдгээ жингээ бас эргэж харахгүй бол. Мэдээж би энэ 41 Их Хурлын гишүүний оруулж ирж байгаа энэ ажлыг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа.

Гэхдээ энэ дээр би яамны мэдэгдлийг сонсохоор нэг аюултай санагдаад байгаа байхгүй юу. Дүн нь буурна, авах мөнгөний хэмжээ буурна гээд асуудал гараад байна. Тэр сан нь, мөнгө нь багасна гээд. Тийм ээ. Тэгвэл тэр багасаж байгаа тэр ачаалал нь энэ Нийгмийн даатгалын сангийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нуруун дээр яаж тусах вэ гэдгийг тооцоолж байж шийдвэр гаргах хэрэгтэй байгаа байхгүй юу. Түүнээс биш.

Яагаад гэхээр Нийгмийн даатгалын сан бол ажил хийж байгаад эрсдэлд орох л... /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмэлт 1 минут. О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Одоо угаасаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 20 жил төлж байж тэтгэвэрт гарч байгаа хүн аягүй цөөхөн байгаа. Тийм тоо ч алга байгаад байна шүү дээ. Тийм ээ. Арай чүү гэж хувь тэнцүүлснээр явж байгаа. Гэтэл хувь тэнцүүлсэн тэтгэвэр нь өөрөө дүн нь ерөөсөө өсдөггүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийж байгаад 3 жил төлсөн дүн нь хүрэхгүй бол ажлаас халагдаад ажилгүйдлийн тэтгэмж байхгүй.

Тэгэхээр манай энэ нийгмийн даатгал халамжийн бодлого бүхэлдээ яагаад байгаа гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ерөөсөө ажил хийхийг ерөөсөө дэмжихгүй ийм механизм харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо байгаа тогтолцоо ийм байхад би энэ хэсэгчилсэн зүйл, заалт дээр шийдвэр гаргана гэхээр миний хувьд аягүй DILEMMA_[хүнд сонголт хийх нөхцөл] үүсчхээд байна л даа.

Тэгэхээр би энэ дээр яам энэ хуулийн төслөө тэр нийгмийн даатгалынхаа шинэчлэл, үзэл баримтлал дотор миний ярьж байгаа асуудал орсон уу, ороогүй юу гэдгийг сонсмоор байна.

Орвол нэгмөсөн цэгцэлж хооронд нь уялдаа холбоотой ярихгүй бол ажил хийж байгаа хүмүүс гэдэг нэг масс дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ бас хохироочих уу гэдэг тийм болгоомжлол байгаад байна. Энэ дээр бас тодруулга авмаар байна.

Л.Энхнасан: Л.Мөнхзул дарга хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Ер нь нийгмийн даатгалын үндсэн зорилго юу юм бэ, яагаад ажил олгогч төлдөг юм бэ гэхээр энэ бол 1800-аад оноос гарч байсан Германы канцлер Бисмаркийн тогтолцоо. Тийм ээ. Bismarck, Beveridge гээд байгаад байдаг. Бүх гишүүд мэдэж байгаа.

Ерөөсөө хүн хөдөлмөр эрхэлснийхээ төлөө яг тоног төхөөрөмж шиг капиталын элэгдэлд ордог. Яагаад гэхээр нэг насаар хөдөлмөрийн чадвар буурч байдаг, эрсдэлд өртөж болдог, хөгжлийн бэрхшээлтэй болж болдог, өндөр настай болоод ажиллах боломжгүй.

Тэгээд энэ тохиолдолд өөрөөр хэлбэл тэр хүн хөдөлмөр эрхэлснийхээ төлөө, бүдүүлгээр хэлэхэд элэгдэл, хорогдол тооцсоных нь төлөө төлж байгаа шимтгэл ч гэж бүдүүлгээр тайлбарлаж болно. Онолын хувьд.

Тэгэхээр тэр хүний хувьд энэ бол тэтгэвэр болон тэтгэмж болж олдог.

Сүүлийн жилүүдэд О.Саранчулуун гишүүний хөндөж байгаа эмзэг сэдэв дээр бас тохиолдол гарч байгаа.

Эрүүл мэнд магадлалын зөвлөлөөр, комиссын хурлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадвар алдалтыг тогтоодог. Тэгэхэд ихэнх нь нийгмийн даатгалын тэтгэврийн эрх үүсэхгүй байна. Гэтэл... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 2 дугаар микрофон.

Л.Мөнхзул: Гэтэл Монгол Улс бол хөгжлийн бэрхшээлтэй хүний Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах хамгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй орнуудын нэг байдаг.

Олон улсын стандарт бол сүүлийн 5 жилийн хугацааны 3 жилд нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх гэдэг стандарт хэрэгжиж байгаад насжилт нэмэгдсэнтэй холбогдуулаад ер нь 5 жил шимтгэл төлсөн байх ёстой гэдэг ийм шаардлага тавьдаг.

Монгол бол 36 сарыг тавьдаг. Амьдралынхаа туршид 36 сар нийгмийн даатгалын шимтгэл төлөөд, ямар нэгэн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй бол тэр хүн насан туршдаа тэтгэвэр авах баталгаагаар хангагддаг.

Гэтэл сүүлийн жилүүдэд Нийгмийн даатгалын сангаас 3 жил шимтгэл төлсөн тийм хүмүүсийн тоо нь буураад нийгмийн халамжийн тэтгэвэр лүү явах тоо их нэмэгдэж байна.

Энэ нь юу вэ гэхээр гадаадад хөдөлмөр эрхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй болдог, хөдөлмөрийн чадвараа алдаад ирдэг. Тэтгэвэр, тэтгэмжийн эрх үүсдэггүй гээд.

Нөгөө талаасаа цалин хөлсийг хэт доогуур, ялангуяа залуу ажиллагсдын хувьд нуун дарагдуулснаас болоод бага хэмжээний цалингаас тэтгэвэр тогтоохоор доод хэмжээн дээр ч хүрдэггүй учраас ихэнх нь доод хэмжээгээр авах гэсэн ийм бас нийгмийн хамгааллын баталгаа алдагдаж... /минут дуусав/

Л.Энхнасан: Тодруулга. О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Тийм учраас бид нийт хүн амын тоог аваад үзэхээр жишээлбэл бид 500 мянган хүний асуудал ярингуут тэнд нэг ажил хийж байгаа 57 мянган хүний асуудал бол цөөнх юм байна. Энэ олонхоо бодоод шийдчихье гэхээр энэ аягүй осолтой байхгүй юу.

Тэр 57 мянган хүн байлаа гэхэд түүний чинь цаана амьдрал байгаа. Тэгэхээр 57 мянган хүн ажил хийж байгаа.

Тэгэхээр хэрвээ би хөгжлийн бэрхшээлтэй байгаад, би жишээлбэл өнөөдөр бага дүнгээр төлж байна. Яах вэ, амьдрал амьдрал дээр бол бага дүнгээр төлж байна. Миний ажил олгогч бага дүнгээр төлж байгаа. Гэхдээ л төлж байгаа бол төлж байгаа. Төлж байгаагийнхаа оронд өнөөдөр ажилгүйдлийн тэтгэмж ч авахгүй. Байр, орон сууц худалдаж авсны буцаалт ч ер нь одоо хүн амын татвар дээр ч тэр, нийгмийн даатгал дээр ч тэр буцаах бенефит буюу үр ашиг ерөөсөө байхгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь энэ бүх л тогтолцоон дээр ийм ээлгүй байгаа юман дээр би юунд яагаад байгаа вэ гэхээр хэсэгчилж ингэж орох нь зарчмын хувьд зөв

боловч том тогтолцоогоо өөрчилж чадахгүй улам дордуулаад дунд нь хүмүүсийг хохироох уу гэдэг ийм болгоомжлол надад... /минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Ө.Шижир гишүүн орж ирсэн бас асуулт асууя гэсэн. Нэрийг нэмээрэй.

Ингээд С.Зулпхар гишүүн асуултаа асууна уу.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн энэ өдрийн амаргаланг айлтгая.

Би дөрөв, таван асуулт байна. Юуны өмнө бас яах вэ бид ингээд нийгмийн хувьд бас хүлээлт үүссэн том асуудал байгаа л даа. Үүнтэй холбоотойгоор манай Их Хурлын гишүүд хууль санаачлаад явж байгааг сайшааж байна. Нийгмийн хүлээлтэд нийцсэн байдлаар тодорхой шийдвэр гаргуулах, бас л энэ чинь том өөрийнх нь үүрэг учраас үүргээ хэрэгжүүлэх гэсэн санаачилга шүү дээ.

Хоёрдугаарт, бид энд 4 тал сууж байна. Хууль санаачлагч нар, байнгын хорооны гишүүд, төрийн захиргааны байгууллага болон ажлын хэсэгт судалгаа хийж өгсөн судлаачдын бүрэлдэхүүн гэдэг.

Асуудлыг ингэж их олон талаас нь бид ингэж хэлэлцэж байгаа нь их сайн болж байна. Нийгэмд бид аливаа зүйлийг зөв ойлгуулах талд хандах ёстой. Тэгэхгүй бол нийгэм хүсэж байна гээд л тэрийг заавал шийдвэр болгох гээд л дайраад байх юм бол бид маргааш зүгээр байж байгаа тогтолцоог ч эвдэж магадгүй. Эцсийн дүндээ нийгмийн ямар нэгэн одоо жишээ нь төвөгтэй хүндрэлтэй байдал үүсгэж магадгүй.

Үүнийг бид ер нь хууль тогтоогчдын хувьд маш сайн ойлгож авах ёстой. Бидний үүрэг аливаа хүсэл болгоныг биелүүлэх биш, бидний гаргасан шийдвэр тооцоо судалгаатай рационал байх ёстой. Эцсийн дүндээ мэдээж хэрэг ажилладаг, үр дүнтэй ийм шийдвэр байх ёстой гэдэг талаас нь бодох ёстой байх гэж бодож байна.

Сая их тодорхой тоо хэлсэн. Энэ тоог угаасаа бид мэдэж байгаа. 2024 оны Нийгмийн даатгалын сангийн орлого бол 5.8 их наяд юм.

Одоо ингээд бид хэрвээ энэ хуулийн төслөөр өөрчлөлт ороод ирэх юм бол Нийгмийн даатгалын сангийн орлого 1.3 их наядаар. Хамгийн бага тооцоолол бол 800 тэрбумаар энэ дутах юм байна. Би хэлж байгаа. Нэг жишээ нь заалт нь шүү дээ. Ялангуяа тэр хоол, унааны зардалд оногдсон шимтгэлийг авахгүй тохиолдолд.

Тэгэхээр ийм хэмжээний эрсдэл бол үүсэж байна гэж байгаа юм. Энэ чинь сангийн орлогын 15 хувь шүү дээ.

Тэгээд буцаад бид үүгээр чинь тэтгэврээ тавьдаг. Одоо тодорхой хуримтлал үүсгэж байгаа. Тийм ээ. Нэг иймэрхүү шинэ хуулийн бас сайн зүйлүүд байна.

Гэхдээ сая Л.Мөнхзул дарга хариулахдаа энэ дээр тодорхой хэлбэрээр зохицуулалтууд хийх ёстой байх, хязгаарлалтууд тавих ёстой байх гэж байна. Энэ дээр манай ажлын хэсгийнхэн бодож тооцоолол хийсэн, ажилласан зүйл байна уу? Үүнийг сонсмоор байна.

Нэгэнтээ бид ганцхан зүйл дээр ярих гэж байгаа биш шүү дээ. Энэ чинь олон хувилбартай байж байж, зөв тооцоон дээрээс л бид хэрвээ үүнийг шийдвэр гаргах бол яах вэ гэдэг ярих ёстой учраас. Тэгэхээр нэгдүгээр асуулт энэ.

Хоёр дахь зүйл бид зөвхөн тэтгэврийг яриад байна. Энэ нийгмийн даатгалын шимтгэл төлсөнтэй уялдуулсан байдлаар зөвхөн тэтгэвр олгогддоггүй юм. Тэтгэмж олгогддог, төлбөр өгөгддөг, зардал гардаг юм.

Бид дандаа ингээд нийгэмд энэ даатгалын сан гэдэг бол тэтгэвр юм шиг ойлгоод шүү дээ. Ажилгүйдлийн тэтгэмж авна. Жишээ нь, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авна. Одоо энэ чинь нөгөө тэжээгчээ алдсаны тэтгэврээ авна гээд бусад төлбөрүүд бий.

Тэгэхээр багцаагаар тоолъё. 505 мянган хүн тэтгэвр авч байгаа. 230-аад мянга... /минут дуусав/

Л.Энхнасан: 1 минут нэмнэ үү.

С.Зулпхар: Тэгэхээр би дахин асуух гээд байгаа юм.

Саяын 760-аад мянган хүний тэтгэвр, тэтгэмж, төлбөр одоо жишээ нь зардалд нөлөөлж байна уу? Энэ тооцоолдыг Та бүхэн хийсэн үү? Энэ бол маш чухал зүйл шүү. Маргааш шууд үүнтэй холбоотой. Энэ чинь эрсдэл хуваадаг л сан шүү дээ. Түүнээс биш хүн болгон өдөр болгон ямар нэгэн бенефит буюу үр ашиг хүртээд сууж байдаг сан биш шүү дээ.

Бид бас их өрөөсгөл нийгэмд ойлголт өгч байгаа учраас.

Дараагийн зүйл. Их чухал тооцооллууд хийсэн байна. Б.Түвшин гишүүн ээ. Макро эдийн засгийн Та бүхэн үр өгөөжийг нь тооцож. 700 тэрбум гэж. Нөгөө талдаа Та бүхэн нийгмийн хамгааллын эрсдэлийн сая тоог нь сонслоо шүү дээ. 1.3 их наяд.

Тэгэхээр макро эдийн засгийн өгөөжийг тооцохоос гадна энэ бодлого чинь нийгэм, эдийн засгийн бодлого гэсэн үг шүү дээ. Нийгэм, эдийн засгийн. SOCIAL AND ECONOMIC POLICY байхгүй юу.

Тэгэхээр энэ бүгдээс нь аваад үзэх юм бол энэ хоёрын зөрүүн дээр тооцоолол хийж үзсэн үү? Үүнээс шалтгаалсан байдлаар хэр... /минут дуусав/

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн хариулна уу. Дараа нь ажлын хэсгээс.

Б.Түвшин: Үнэхээр одоо манай Сангийн яамныхны ярьж байгаагаар энэ Нийгмийн даатгалын сан бол алдагдалтай яваа. 700 орчим тэрбум байна. 1.4 их наядын шилжүүлэг авахаар байгаа гээд тооцоо ярьж байгаа.

Тэгэхээр энэ бол үнэн. Яг одоо бодит байж байгаа тоо. Ямар нэгэн хуулийн өөрчлөлт ороогүй. Энэ байж байгаа бодит байдал л ийм байгаа шүү дээ.

Үүний нөгөө талд нь орлогыг шахаж нэмэгдүүлэх гэдэг бүх бодлого явсан. Бизнесийн болон бүх хувь хүнтэй хийсэн гэрээнээс орлогоо авсан. Цаашдаа үүнийг ингээд харах юм бол бизнесийнхээ орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр тал нь хоёулаа төлдөг ийм байдлаараа явах юм бол буцаагаад хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бүх ажил эрхлэгчдийг дуусгачхаж байгаа байхгүй юу.

Энэ чинь өөрөөр хэлбэл бизнесийнхээ орлогоос 20 хувийн нийгмийн даатгалд, дээрээс нь хүн амын орлогын албан татвар 10 хувь, буцаагаад НӨАТ-ын 10 хувь гээд.

Тэгэхээр энэ чинь олон улсад бараг байдаггүй буюу бизнесийн орлогоосоо төлдөггүй жишиг учраас үүнийг бид залруулахгүй бол зөвхөн Нийгмийн даатгалын сангийн алдагдал гэхээсээ илүү ажилгүйдэл ихсээд, цаашаагаа ерөөсөө монгол хүн гэдэг хувь хүнийхээ нэрээр ерөөсөө бизнес эрхлэх ямар ч боломжгүй болж байгаа учраас үүнийг бид залруулах ёстой гэж нэг талаасаа үзэж байгаа.

Хоёрдугаарт, хоол, унааны хөнгөлөлтийн асуудлуудын тооцооллын зөрүүнүүд байж болж байна. Болно. Энэ чинь сэтгэлгээний л асуудал байгаа. Зарим хүн үүнийг чинь хоол, унаа татваргүй болсон бол нэмээд өгчихье гэж тооцож байна. Одоо бол тэр их тооцоод байгаа чинь 100 хувь одоо байж байгаа дүнгээсээ шууд хасаад авчихъя л гэж тооцож байна.

Энэ яаж тооцоолохоосоо болно. Бид нарын тооцоолж байгаа тооцоолол бол одоо авч байгаа нийгмийн даатгалыг нэгийг нь ч бууруулахгүй. Харин одоо тодорхойлсон хоол, унааны хөнгөлөлт гээд энэ статистик дээр мэдээлсэн тэр дүнгүүдээс нь өсгөхгүй хэмжээнд л бууруулна уу гэж байгаа болохоос биш яг

энэ хоол, унааны дүнг нь үндсэн цалингаас нь хасаад явуулчихна гэдэг ийм ойлгоц байхгүй.

Ер нь эдийн засгийн логик агуулгын хувьд хоол, унаа энэ байр, түлшний хөнгөлөлт гэдэг бол өөрөө яг хүмүүсийн бодит гар дээр очиж байгаа буюу бас нөгөө талаасаа эдийн засгийн эргэцийг нэмэгдүүлдэг зүйл. Жишээлбэл, төсвийн хүмүүсийг одоо 100 хувь эндээсээ хасагдлаа гэхэд төсвийн зардал бас нөгөө талаасаа багасна.

Тэгэхээр энэ чинь дандаа хоёр талтай байж байгаа. Макро эдийн засгийн үзүүлэлт болон нийгмийн үзүүлэлтүүдийг тооцсон. Макро эдийн засгийн үзүүлэлт, ялангуяа тэр COST-BENEFIT-ээр тооцохоороо нийгмийн гарах энэ зардлуудыг нь тооцоод, энэ зардлууд нь өөрөө эргээд ямар эдийн засгийн өгөөжийг авчрах вэ гээд. Тэгээд цэвэр өгөөжийг нь тооцоод яриад байгаа нь дүн нь бол тэр 3 жилээрээ cost-benefit analysis-аар 271.8 тэрбум төгрөг байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ гарах зардал, үүнийг гаргах зардлыг одоо тэр байж болох зээлийн хүүгийн дунджаар нь дискаунталж бас тэр зээлүүдийг нь гаргуулаад, тэгээд өнөөгийн үндсэн рүү ингэж тооцоолсон хувиргалтууд тооцож байгаа юм.

Тийм учраас бүх зардал тооцоолж байгаа юм.

Энэ зөрүүтэй асуудал буюу ялангуяа энэ гурван... /минут дуусав/

Л.Энхнасан: Дуусгаж хариулна уу.

Б.Түвшин: Энэ гурван заалтын ялангуяа тооцоолол дээр бол хоёр дахь заалт буюу хоол, унааны хөнгөлөлт гэдэг энэ концепц дээр магадгүй одоо бид хэлэлцсэний дараа хоёр талаасаа энэ концепц яаж импакт үзүүлэх вэ гэдэг дээр нь сууж ойлголцож бас болох байгаад байгаа.

Аргагүй яг одоогийн хэрвээ энэ ядуурал ихтэй байна, ажил бизнесүүд дуусаж байна гэх юм бол шууд цалингаас нь хоол, унаагаа хасна гэдэг нэг аргачлал бас авч үзэх талтай.

Өнөөдөр нийгэм, эдийн засаг сайжирч байна, хүмүүсийн гар дээрх нэмэгдүүлье, нийгмийн даатгалгүйгээр хоол, унааны мөнгийг нэмдэг больё гэвэл энэ чинь нэмэгдэж тооцно.

Яг статистик дээр байгаа энэ тооцож байгаа дүнгээс бууруулахгүйгээр энэ хоол, унааны хөнгөлөлтийг сонгодог утгаар нь явбал энэ чинь дахиад өөр тооцоо гарна.

Тийм учраас нөгөө аль ч талаас нь яаж ч ярьж болдог ийм сэтгэлгээний хүмүүс. Хүмүүсийн хүлээлт нь явсаар байгаад 50, 50 л явдаг.

Тэгэхээр үүнийг бас аль алийг нь бүрэн үгүйсгэж болохгүй тооцоолол учраас энэ хоёрдугаар заалтын тооцоон дээр дахин тал талаасаа сууж... /минут дуусав/

Л.Энхнасан: Ажлын хэсгээс. Яамнаас хариулах уу? Л.Мөнхзул дарга сая Төрийн байгуулалтын байнгын хороонд дуудагдаад явчихлаа. Яамнаас Б.Батжаргал дарга л 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: С.Зулпхар сайдын асуултад хариулъя.

Энэ Нийгмийн даатгалын сангийн баланс бол орлого ба зарлага гэсэн хоёр л үзүүлэлттэй. Орлого хэсэг дээр бид орлогоо төвлөрүүлээд, зарлага дээр бид нийгмийн даатгалын багц хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжүүдээ буюу 24 үйлчилгээг л санхүүжүүлж буцаагаад гаргаж байгаа юм.

Тэгэхээр бид орлого тал дээрээ бид орлого буурна гэдэг бол яах вэ, зарим нэг нөлөө үзүүлээд, ажил олгогчийн тоо ихсээд, нийт дүнгээрээ сангийн орлогод тодорхой нөлөө үзүүлж магадгүй. Гэхдээ тухайн хүний хувьд гарцаагүй шууд нөлөө үзүүлнэ. Тухайн хүний хувьд 2 сая төгрөгөөс нийгмийн даатгал төлдөг байсан бол хоолны мөнгийг нь 400 мянга хасаад, ингээд сая 600 мянган төгрөгөөс шимтгэл төлбөл энэ дүнгээс нь л бид нөгөө шударга зарчмаараа тэтгэвэр юм уу, тэтгэмжээ л олгоно.

Тэгэхээр С.Зулпхар гишүүний хэлдэг санаа бол зөв. Тэтгэврүүд, декретүүд, листүүд, оршуулгын тэтгэмж. Оршуулгын тэтгэмж орохгүй. Тэтгэврүүд ингээд бүгдээрээ... /минут дуусав/

Л.Энхнасан: С.Зулпхар гишүүн тодруулна уу?

С.Зулпхар: Баярлалаа. Их чухал ингээд хэлэлцээд явахаар зэрэг бид нарийн ширийн зүйлүүдээ ойлгож байна шүү дээ.

Б.Түвшин гишүүн ээ, ахиад нэг асуулт. Одоо танай ажлын хэсэг дээр та хэд бол маш чухал тооцооллууд хийсэн байна. Модель бол зөв л модель байна л даа. Макро эдийн засгийн нөлөөлөл нь ямар байх юм. Одоо эндээс ямар уршиг гарах юм? Бүр цаашид cost-benefit analysis хүртэл хийсэн юм шиг байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр нэмж өөр хувьсагчууд та нар оруулж ирээгүй юу? Би саяын хэлээд байгаа үүний нийгмийн эрсдэлийг тооцдог тэр тодорхой хувьсагчууд байж байна. Түүний эерэг байна уу, сөрөг байна уу гэдэг тооцоолол хийсэн үү? Сая одоо шууд л бидэнд нэг тоо сонсгох л юм бол бидэнд бараг хариултаа олчхож байна шүү дээ. Хамгийн энгийнээр 1.3 их наядын тэр сангийн орлого дутах юм бол үүнийг чинь дагаад тэртээ тэргүй энэ сан бол

ажиллагаагүй болчхож байна л гэсэн үг байхгүй юу. Зүгээр хамгийн энгийн хариулт.

Тэгэхээр бид тэрийг тооцно уу? Нэгдүгээрт. Тооцсон байлаа гэхэд бид саяын хэлсэн үүнийг яаж ер нь зохицуулах юм? Ганцхан тэр заалтаар нь тэр чигт нь хийх юм уу, эсвэл түрүүн хүмүүс яриад байна. Тодорхой хязгаарлалтаа... /минут дуусав/

Л.Энхнасан: Б.Түвшин гишүүн хариулна уу.

Б.Түвшин: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Яг одоо байгаа статистик тооцооллоос үүнийг яг одоогийн байж байгаа статистикаас нь хоол, унааны мөнгийг нэмэгдүүлэх гэдэг өнцгөөр ингээд аваад явах юм бол энэ нөлөөлөл өөрөө 300 орчим тэрбум төгрөгийн нөлөөлөл.

300 орчим тэрбум төгрөгийн нөлөөлөл гэдэг чинь тухайн сангийн өсөж байгаа жил болгон хөдөлдөг дүнгийнх нь одоо ерөөсөө л гуравны нэг байхгүй юу. Үнэхээр яг энэ хоёрдугаар заалтын тооцоолол 1.8 их наяд руу ороод ирвэл энэ чинь бол харин бодит сан дээр тодорхой нөлөө үзүүлнэ.

Тийм учраас үүний аргачлалуудыг бид хоёр талаасаа сууж хийх нь зүйтэй. Энэ бол нөгөө пессимист болон өөдрөг гэсэн хоёр аргачлалууд байж байгаа.

Тэгэхээр энэ тооцооллын дүнг хоёрдугаар заалт дээр өнөөдөр бид хоёр талаасаа ажлын хэсэг гаргаж байгаад суулгачихад бол бас болохоор болж байна. 1, 3 хоёр дээр бол харьцангуй ойролцоо тооцоо орж байгаа юм байна гэж ингэж ойлголоо.

Л.Энхнасан: М.Ганхүлэг гишүүн асуултаа асууна уу?

М.Ганхүлэг: Товчхон нэг асуулт асуучихъя.

Бусад гишүүдтэй давхардаж магадгүй. Сая ажлын хэсгийн хуралтай байж байгаад орж ирлээ.

Нийгмийн даатгалын хууль, татварын багц валюттай холбогдолтой асуудлыг бас нэлээн сууриар нь хараад, ялангуяа Сангийн яам, одоо яг салбарын яамд өөрсдөө нэлээн сайн ажиллаад оруулж ирэх нь зөв өө гэсэн ийм байр суурьтай байдаг. Тэр агуулгаараа Засгийн газраас өргөн барих гэж байгаа төсөл бас байгаа гэдэг ийм мэдээллийг бас авсан байгаа.

Тэгэхээр ер нь хэлэлцүүлгийн шатад төслүүдийг нийлүүлээд, мөн гишүүдийн гаргаж байгаа саналуудыг тусгаад ингээд хамтатгаад явах боломж бололцоо юм нь ямаршуу байх бол оо гэдэг талаас нь асууя.

Гишүүдийн зүгээс олуулаа бас өргөн барьж байгаа энэ асуудлыг би бас хүндэтгэн үзэж байгаа. Хэлэлцэх шатад нь үндсэндээ хэлэлцээд тэгээд хооронд нь уялдаа холбоог нь хангаад явах ийм саналтай байгаагаа илэрхийлчихье. Тийм.

Л.Энхнасан: С.Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу?

Уучлаарай. Асуулт асуусан юм байна. Яамны төлөөлөл Л.Мөнхзул дарга гарсан. Хэн яв хариулах вэ? Ажлын хэсэг Б.Батжаргал дарга 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төсөл дээр байгаа гурван агуулгын ер нь хоёр нь шууд утгаараа яамнаас боловсруулсан хуулийн төсөл дээр байгаа. Нэг асуудлыг бид арай өөрөөр томъёолж байгаа. Гэхдээ төстэй.

Тийм учраас ингээд өргөн бариад хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явсан тохиолдолд дараагийн процесс дээр нэгтгээд нэг ажлын хэсэг гаргаад хэлэлцээд явах боломж байгаа болов уу гэж бодож байна. Энэ дээр дэгээрээ ямар байдгийг нь бол сайн мэдэхгүй байна. Ер нь боломжтой гэж харж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Энэ нэг, хоёр гэдэг нь яг ямар асуудал билээ? Танайхаас яамнаас ирсэн танилцуулгыг харахад ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэлийг уян хатан ногдуулна гээд нэг уян хатан гэсэн юу тавьсан байгаа. Тэгээд тэр нь яг юу гэсэн үг вэ?

Нөгөөдөх нь, ажил олгогчийн шимтгэл төлөх цалин хөлсөнд дээд хязгаар тогтооно гэсэн байгаа. Энэ нь дэмжигдэж байна гэсэн үг үү. Тийм ээ.

Тийм боломж байгаа юу? Б.Түвшин гишүүн хариулна уу.

Б.Түвшин: Ер нь үндсэн гурван зохицуулалт орж ирж байгаагийн нэг, гурав дахь хоёр зохицуулалтаар зарчмын хувьд санал нийлж байгаа тохиолдолд бид үүнийг хэлэлцэхээр явуулчихъя.

Хоёрдугаар асуудал дээр тооцооллын зөрүү гараад байгаа.

Тэгэхээр энэ тооцооллын зөрүүг одоо бид гаргах хоёр талын ажлын хэсгүүдээ хэлэлцэхээр явуулчихаад, дараа нь үүнийгээ хийгээд. Энэ дээр зарчмын шийдэл олж болох байх.

Засгийн газраас өргөн барьж, одоо яг энэ асуудлыг өргөн бариагүй, магадгүй хэзээ ч барих юм байгаа юм. Ийм учраас одоо яг зэрэгцээд өргөн бариад явчихвал цугтаа хэлэлцээд явахад бас болно. Цаг хугацаа алдахаар бол

энэ тооцооллын зөрүүн дээрээ хэлэлцэж байх явцдаа аль нэг тал хоёулаа ойлголцоод явах бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

Л.Энхнасан: С.Эрдэнэбат гишүүн асуултаа асууна.

С.Эрдэнэбат: Энэ хэдэн асуулт асуучихъя.

Яг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш цалин авдаг хэдэн хүн байдаг юм? Нийгмийн даатгал шимтгэл төлдөг. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, энэ хуулиудтай холбоотой асуудлуудыг нийгмийн эрх ашгийг төлөөлж байгаа нөгөө ажил олгогч нар, үйлдвэрчний эвлэл. Эдгээр хүмүүсээсээ ер нь санал авч байж оруулж ирдэг байх зарчим байгаа.

Тэгэхээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс яг энэ асуудлаар хэлэлцсэн үү? Засгийн газрын боловсруулж байгаа хууль болон энэ хуультай холбоотойгоор санал авсан уу гэдгийг бас хэлмээр байна.

Дараагийнх нь хоол, унаа, орон сууц гээд үүний өмнөх хууль дээр би санал өгөөд дэмжигдээгүй үлдэж байсан юм. Үүнийг би дэмжиж байгаа. Ер нь бол. Өөрөөр хэлбэл тэр ажилтан хүнд хоол, унаа, тэр тог цахилгаан байна уу, түлээ нүүрс байна уу үүнээс нь суутгах юм бол хэвийн ажиллах нөхцөлийг нь хангасных нь төлөө давхар давхар шимтгэл юугаар дарамт болоод байх энэ асуудлыг нь хасчхаач ээ гэдэг саналыг үүний өмнөх хуулийн төсөл дээр өгөөд дэмжигдээгүй. Харамсалтай нь.

Тэгэхээр одоо дахиж орж ирж байгаа бол зарчмын хувьд үүнийг дэмжиж байгаа. Гэхдээ хэмжээтэй байх ёстой.

Яах вэ, би гайхаад байна л даа. 20 мянган төгрөгтэй холбоотойгоор ярихад тийм их хэмжээний даатгалын дутагдал орж ирнэ гэдэг бол тэр тооцоолол дээрээ яг нарийн суухгүй бол энэ өөрөө эргээд нөгөө талдаа сангийн хувьд нэлээн эрсдэл болоод ороод ирдэг гэдгийг хэлмээр байна.

Дараа нь, хөлсөөр ажиллах гэрээ гээд. Б.Түвшин гишүүнтэй нь түрүүн бас уулзсан. Яах вэ, нөгөө талдаа тодорхой хэмжээгээр бас зааглаж шийдэхгүй бол маш олон үндсэн гэрээгээр ажиллаж байгаа юмнуудаа зүгээр хөлсөөр ажиллах тийм гэрээ рүү шилжүүлэх эрсдэл. Магадгүй энэ хоол, унаанаасаа илүү өндөр эрсдэл гарч ирэх эрсдэлтэй байдаг.

Тийм учраас дундын хувилбараар зүгээр нэг удаадаа нэг байшин гэрээ янзлуулдаг ч юм уу, нэг ажил гүйцэтгэх гэрээгээр нэг хуулийн зөвлөгөө авдаг ч гэдэг юм уу. Тийм ээ. Ийм удаагийн шинж чанартай юмнуудаасаа хасаад хаячих нь бол зөв.

Харин олон удаа давтагддаг байдлаар үүнийгээ ингээд шийдэх юм бол хөдөлмөрийн гэрээ байгуулах хүн олдохгүй. Бүгдээрээ татвар, нийгмийн даатгалаасаа зугтаагаад ийм гэрээ байгуулаад явах юм бол энэ сан чинь өөрөө том эрсдэлд ороод. Бүр зөрүүлээд ажил олгогч нараас нийгмийн даатгалынхаа шимтгэлийг нэмье гэдэг юм руу ороод ирэх вий гэдэг би энэ эрсдэлийг бодоод байгаа.

Саяхан бид чинь 5 пунктийг нэмж оруулж ирж байсан шүү дээ. Олон Улсын Валютын Сангийн юугаар орж ирээд.

Тийм учраас энэ эрсдэлүүдээ би хараарай гэж бодож байна. Тэгээд хуулийн хувьд бол яах вэ нэгтгээд хэлэлцээд ингээд явах нь бол зөв байх.

Ер нь бол хэлэлцэх эсэх дээр миний хувьд дэмжиж байгаа.

Нэг асуулт нь, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой ингэж холбоод байх нь өөрөө эргээд нөгөө хөдөлмөрийн хөлснийхөө доод хэмжээг нэмэхгүй байх сонирхлыг шууд өдөөж өгөх зүйл.

Тийм учраас миний хувьд ер нь цаашдаа тэр Засгаас өргөн барьж байгаа юмнуудаа амьжиргааны баталгаажих доод түвшин гэдэг юм уу, энэ зүйлтэйгээ холбож өгөхгүй бол ажил олгогч нарын үүнийг дэмжихгүй байдаг нэг шалтгаан нь надад ирэх дарамт нэмэгдээд байх юм байна гэдэг нэг ийм асуулт байгаад байдаг юм. Цалингаас гадна. Тийм.

Л.Энхнасан: Хэн хариулах вэ? Б.Түвшин гишүүн хариулаад, тэгээд Б.Батжаргал дарга хариулна уу.

Б.Түвшин: С.Эрдэнэбат гишүүний тэр нөгөө хөдөлмөрийн шинж чанартай харилцаанаас бусад Иргэний хуулийн харилцаа руу шилжүүлээд зайлсхийгээд байх ийм эрсдэл байгаа юу гэж асуусан.

Тэгэхээр ийм эрсдэл бол байж болох талтай.

Тэгэхээр төсөл дээр нэг ийм заалт оруулсан байгаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 41.3 дээр ажил олгогч, ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 41.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно. Хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулсан боловч уг харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн шинжийг агуулсан байвал түүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцно гэж байгаа.

Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн гэрээний шинж чанарыг л агуулсан бол өөрөөр ямар ч нэрлэж болохгүй. Хөдөлмөрийн гэрээ гэж үзнэ гэсэн энэ заалтыг оруулаад ямар санкц оруулж өгч байгаа вэ гэхээр энэ байдлаар зайлсхийсэн байх юм бол бүх нийгмийн даатгалыг нь нөхөн төлүүлнэ гээд заасан.

Тэгэхээр энэ агуулгаараа одоо яг энэ төсөл дээр орж ирж байгаа учраас хөдөлмөрийн гэрээг өөр гэрээ болгож хувиргах заалтыг нь хааж өгсөн заалт болж байгаа.

Л.Энхнасан: Б.Батжаргал дарга нэмж хариулна уу.

Б.Батжаргал: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Хөдөлмөрийн хөлсний хэмжээгээр нийгмийн даатгал төлдөг хүний тоо 2024 оны эцсийн байдлаар 280 мянган хүн албан журам дээр, 134 мянган хүн сайн дур дээр байгаа гэсэн ийм тоо статистик байна.

Хоёр дахь асуултын хувьд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс санал авсан уу гэсэн ийм асуулт асууж байна. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаман дээр боловсруулаад Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлээд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд байгаа мэргэжлийн хороогоор бас дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн байгаа. Засгийн газрын боловсруулсан хуулийн хувьд бол энэ процесс бол хийгдэж байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: С.Эрдэнэбат гишүүн тодруулна уу.

С.Эрдэнэбат: Миний асуултыг буруу ойлгох шиг боллоо. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээшээ 10 дахин буюу одоо хязгаар байгаа шүү дээ. Түүнээс дээшээ цалин авдаг хэд байгаа вэ? Өөрөөр хэлбэл одоо 7 сая 920 мянган төгрөгөөс дээш цалин авдаг хэдэн хүн байдаг юм бэ гэж.

Нэгдүгээр тодруулга. Тийм.

Л.Энхнасан: Б.Батжаргал дарга хариулна уу. 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Тийм. 2024 оны жилийн эцсийн тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс дээшээ цалин авч байгаа хүмүүсийн тоо 17 мянга 500 орчим байгаа. 17 мянга 500. Даатгуулагчийн тоогоороо. Тийм.

Л.Энхнасан: С.Эрдэнэбат гишүүн тодруулна уу.

С.Эрдэнэбат: Би харин түрүүн бас үүнийг асууж байгаа нь 17 мянга орчим хүнд 8 саяас дээш хэмжээний цалин олгож байгаа ажил олгогч нарыг бол дэмжье.

Нөгөөдөх нь тэр тэтгэврийнх нь юунд нь ордоггүй нь бол үнэн. Тэр 8 сая, 9 сая төгрөгийн цалин авч байгаа хүмүүс тогтоолгоход нь энэ ямар ч хамааралгүй. Яг нөгөө хязгаараараа тогтоочихдог.

Нөгөө талаараа бас нийгмийн даатгалын нэг зүйлийг хэлэхгүй бол бас болохгүй зүйл нь юу вэ гэхээр сүүлийнхээ 5 жилийг л маш өндрөөр тогтоогоод хуулийн цоорхойг ашиглаад байгаа юм. Насаараа 30, 40 жил төлсөн хүн бол бараг хөдөлмөрийн хөлсний цалин тэтгэврийн багыг авдаг. Нийт тэтгэвэр авагчдын чинь бараг дийлэнх нь 700, 800-хан мянган төгрөгийг авч байна шүү дээ.

Тэгэхээр цаашдаа бид одоо энэ асуудал дээр анхаарал хандуулахгүй бол зарим хэсэг нь ингээд хожоод байдаг. Барьж авсан хэдийгээ шимтгэлээр нь дарамтлаад байгаад байдаг.

Тийм учраас бүгдээрээ төлдөг, бүгдээрээ ижилхэн эрх эдэлдэг ийм юм руу орох хэрэгтэй. Тэгээд ер нь ахмадуудынын тэтгэврийг доор хаяж мянган доллар луу аваачих гэдэг... /минут дуусав/

Л.Энхнасан: Б.Батжаргал дарга хариулна уу.

Б.Батжаргал: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн бодолт яг түрүүн бас А.Ариунзаяа сайд хэлсэн. Хоёр аргаар бодож байгаа. Нэг нь 5 жилийн дундаж буюу “цалинд суурилсан арга”. Нөгөөх нь “нэрийн дансны арга” буюу хуримтлалын арга буюу ингээд дотроо хоёр хуваагдаж байгаа.

Тэгээд яг төлсөн хэмжээгээрээ тэтгэвэр авах үндсэн шударга зарчим бол тэр “нэрийн дансны арга” болон “хуримтлалын арга” бол энэ бол шударга зарчим руу шууд орно.

Цалинд суурилсан аргыг 5 жилийг байлгаад байхаар бага хэмжээгээр төлж явж явж байгаад тэгээд хамгийн сүүлийн 5 жилээ өндөр төлөөд ингээд гараад ирдэг энэ алдааг засахгүй бол “цалинд суурилсан арга” бол бас сүүлийн үед маш их асуудал дагуулж байгаа юм бол үнэн. Энэ дээр санал нэг байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ө.Шижир гишүүн асуултаа асууна уу.

Ө.Шижир: Нийгмийн хамгааллын яамнаас нэг хэдэн асуулт байна. Эхлээд нэг тоо хэлье.

2025 оны эхний улирлын байдлаар аж ахуйн нэгжүүдийн төлдөг татвар өмнөх оныхтой харьцуулахад 1 их наядаар багассан буюу одоо 1.8 их наяд байгаа.

Яагаад багасаад байна вэ гэхээр нэгдүгээрт орлогын асуудал, нөгөө талаас энэ олон шимтгэлүүдийн асуудал байхгүй юу. Одоо энд хоёр байр суурь байгаад байна л даа.

- ▶ Нэг нь, сан дээр цуглардаг мөнгийг аль болох багасгахгүй байх.
- ▶ Нөгөөдөх нь, түүнийг яаж илүү олон болгох боломжийг бий болгох байгаа юм.

Б.Түвшин гишүүний санаачилсан хууль бол одоо байгаа боломжийг багагүй өөрчлөөд олж байгаа татварыг яаж илүү цуглуулах вэ гэдэг боломж хайсан хуулийн төсөл шүү дээ.

Тэгэхээр нэг талаасаа хэт хаагаад байгаа юм. Нөгөө талаасаа ажил олгогч байхгүй бол та нарын энэ цуглуулаад байгаа нийгмийн даатгалын шимтгэлүүдийг хэн төлөх вэ? Зөвхөн төрийн байгууллагууд төлөх үү?

Тэгтэл 1.2 сая хувийн хэвшилд ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн ажилтнууд байгаа шүү дээ. Энэ тоо багасаад байвал та нарын алдагдлыг хэн өөрчлөх юм, хэн багасгах юм?

Тэгэхээр аливаа хуулийн төсөл, ялангуяа нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой, татвартай холбоотой хуулийн төслүүд өөрөө бизнес эрхлэгч талдаа буюу аж ахуйн нэгж талдаа, орлого бүрдүүлдэг талдаа, татвар төлдөг талдаа зохицуулагдах ёстой байхгүй юу. Тэгж байж бид нарын өнөөдрийн цуглаж байгаа мөнгө илүү яаж олон болох тухай уг нь ярих ёстой юм. Энэ хуулийн төслийн гол зорилго нь энэ юм.

Тэгэхгүй бол одоо яг өнөөдөр яг бодит байдал дээр юу болж байна вэ гэхээр ажил олгогч нар татвараа төлж чадахаа болихоор л та нарын наад сан чинь хоосорчихно. Бид төрийн албаны 228 мянга 500 албан хаагчийн асуудлаар ерөөсөө шийдэж чадахгүй.

Ер нь нийгмийн даатгал чинь шимтгэл биз дээ? Сангийн яамныхан. Тэгээд шимтгэлээс татвар авдаг нь зөв юм уу? Хамгийн эхний асуулт. Шимтгэлээс татвар авдаг байх нь зөв юм уу?

Хоёрдугаарт нь, одоо энэ ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлсөөс нийгмийн даатгалын шимтгэл аваад энэ нь өөрөө зөвхөн Нийгмийн даатгалын сангийн орлогыг л бүрдүүлдэг ийм хэлбэр болчихоод байгаа юм. Гэтэл одоо ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр байгуулсан хүмүүсээс тэр шимтгэлээс нь татвар аваад байхаар аж ахуй нэгж талдаа ямар дарамт учирч байгаа вэ гэдэг бас аягүй том асуудал. Бид бас аж ахуйн нэгжээ бодохгүй байна шүү дээ. Зөвхөн сан бүрдэх тэр орлогоо л бодоод байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн сангийн орлого байхгүй болно. Хэдэн зуун тэрбумаар тасарна ч гэнэ үү нэг иймэрхүү юм яриад байх юм.

Хоёрдугаарт нь, оршин суугч бус этгээдүүдээс бас татвар аваад байдаг. Эд нар эргээд нийгмийн хариуцлага юм уу, тэтгэврийн хариуцлага хүлээхгүй шүү дээ. Тэгээд эндээс бид татвар аваад байдаг.

Тэгээд би та нарт нэг ганц жишээ хэлье. Л.Энхнасан дарга аа, та нэг минут нэмээд өгчхөөч.

Манайх ийм жишээ авч бодсон юм. Жишээ нь, 2 сая 500 мянган төгрөгийн цалин авдаг. Илүү цаг нь 150 мянган төгрөг. Хоолны мөнгө нь 250 мянга. Унааны мөнгө нь 180. Түлээ нүүрс 200 гээд. Одоо энэ хуулийн төсөл дээр байгаа шүү.

Нүүрсний хөнгөлөлт гээд ингээд эндээс хэрвээ одоогийн хуулиар явах юм бол энэ ажилтан 4 сая 680 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөх болж байгаа юм. Одоо байгаа одоо та нарын яриад байгаа хуулиар, хамгаалаад байгаа хуулиар чинь.

Л.Энхнасан: 1 минут нэмье.

Ө.Шижир: Одоо өргөн баригдаж байгаа хуулиар явах юм бол 3 сая 950 мянган төгрөгөөс татвар төл гэж байгаа юм. Ажил олгогч талдаа 493 мянга. Ингээд буурч байна шүү дээ. Тийм ээ.

Энэ буурч байгаа одоо энд та хэдийн яриад байгаа энэ зөрүү чинь өөрөө эргээд л иргэдийн халаасанд бууна шүү дээ. Иргэдийн халаасанд буухаар юу болох вэ гэхээр зах зээл нийлүүлэгдэнэ. Зах зээлээ дахиад тэлнэ.

Энд ер нь яг бизнес эрхэлж байсан, ажил олгож байсан, ажил олгогч хийж байсан, татвар төлж байсан хүн яг одоо энэ 3, 4, 5, 6 номерууд дээр байна уу? Үгүй ер нь.

Би ингэж асуугаад байгаа байхгүй юу? Яагаад гэхээр бид ажил олгогчдоо бодох ёстой байхгүй юу. Тэгж байж бид олох орлогоо олно. Илүү олно. Ажил олгогчдоо бодож байж бид ирээдүйд төвлөрүүлэх тэр шимтгэл, татвар юм чинь илүү нэмэгдэнэ. Байгаа зүйлээ хамгаалаад байвал бид өнөөдөр ямар ч өөрчлөлт гарахгүй. Ямар ч үр дүн гарахгүй.

Гурав дахь асуулт нь. Одоо энэ томоохон төслүүд дээр ажиллаж байгаа цэвэр мэргэжлийн гаднын мэргэжилтнүүдээс бас хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгал... /минут дуусав/

Л.Энхнасан: Гишүүний асуултад хариулна. Сангийн яамнаас 8 дугаар микрофон.

В.Содномдаржаа: Гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа байр суурьтай санал нэг байна. Эдийн засаг томорч байж, аж ахуйн нэгжүүд олширч байж одоо энэ бүх эдийн засаг маань томорч байж сангийн орлого ч гэдэг юм уу, тэрийгээ дагаад нийгмийн даатгалын шимтгэл, татвар нь байна уу бүгд нэмэгдэнэ. Түүнтэй санал нэгдэж байна.

Асуултын тухайд бол шимтгэлээс татвар авч байгаа зүйл байхгүй байгаа. Нийгмийн даатгалын хууль болон хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар.

Тэгэхээр нэмж тодруулбал би танд хариулъя.

Л.Энхнасан: Яамнаас хэн хариулах вэ? Б.Батжаргал дарга. 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Ө.Шижир гишүүний асуултад хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ажил олгогчийг дэмжих нэг бодлого бас одоо өргөн барих гэж байгаа хуулийн төсөл дээрээ боловсруулж оруулсан байгаа.

Энэ дээр оюутнууд болон залуучууд ажил, хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл огт төлөхгүй, зөвхөн үйлдвэрлэлийн ослын даатгал төлнө. Ажилтан огт төлөхгүй байх ийм бодлогыг оруулж ирж байгаа.

Хүн ам дээр бас хөдөлмөр эрхлэлтийн зах зээлийг нэмэх, хүний нөөцийн асуудал бас яригдаж байгаа учраас 160 мянган оюутныг ажлын байран дээр үр дүнтэй ажиллуулах бодлогыг гаргая гэсэн бодлого хийсэн.

Ахмад настнууд бас ажил хөдөлмөр эрхэлбэл ажил олгогч болон ажилтан бас тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байх энэ хувилбарыг 2023 оны нийгмийн даатгалын багц хуульд оруулаад бид хэрэгжүүлээд явж байгаа. Үүнийгээ үргэлжлүүлж бид хэрэгжүүлэх бодлоготой байна.

Ажил олгогчийн тооны хувьд 2023 оны жилийн эцсийн байдлаар 58 мянга 663 нь ажил олгогч Нийгмийн даатгалын санд... /минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 1 дүгээр микрофон.

Б.Батжаргал: Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлж нийгмийн даатгалын тайлангаа бол өгч байна.

Энэ тоо 2023 оны тоо. 2024 оны жилийн эцсийн байдлаар 60 мянга 657 болж ингээд тодорхой хэмжээгээр бас өссөн байна.

Тэгээд ажил олгогчийг дэмжих бодлогын бас нэг Б.Түвшин нарын гишүүдийн өргөн барьсан хуультай яг адилхан нэг бодлого нь тэр дээд тааз тогтоох асуудал хамгийн чухал байгаа. Тэр 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна гэдэгтэй яам санал нэг байгаа гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Тодруулах юм уу? Ө.Шижир гишүүн тодруулга.

Ө.Шижир: Тийм. Сая нэг жишээ аваад байгаа нь нэг нь одоогийн хуулиар, нөгөөдөх нь одоо Б.Түвшин гишүүний өргөн барьсан хуулиар явах л ийм жишээг яриад байгаа юм.

Хэрвээ одоогийн хуулиар хоолны мөнгө. Одоо энэ өргөн барьсан хууль дээр байгаа шүү дээ. Унааны мөнгө гэх мэт зардлуудыг бодогдсон цалин гэж үзэх юм бол 4 сая 600 мянган төгрөгөөс татвар төлж байгаа юм.

Б.Түвшин гишүүний хуулиар ярих юм бол 3 сая 950 мянган төгрөгөөс татвар төлөх болж байгаа юм. Тэгээд энэ чинь хэрэглэгч талдаа гэх юм уу, иргэн тал дээр бол маш том санхүүгийн боломж бүрдүүлээд байна шүү дээ. Тэгээд энэ чинь эргээд л зах зээлд нийлүүлэгдэх байхгүй юу. Эргээд зах зээлийн хувьд дэмжсэн л ийм юм болно.

Одоо бид чинь 93 их наядын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй болно гээд Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр чинь байгаа. Одоогийн нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдлаар бид юун 93, 80. Одоо та нарын нийгмийн даатгалын шимтгэл, аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар 1 их наядаар дутсан байгаа татвар чинь дахиад доошоо явна шүү дээ. Одоо бид эртхэн ийм арга хэмжээнүүд аваад сэргийлсэн юмнуудаа хийхгүй бол ингээд араас нь явах болно.

Тэгэхээр битгий хоёр өөр байр суурь илэрхийлээд... /минут дуусав/

Л.Энхнасан: Үг хэллээ. Тийм ээ. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. С.Зулпхар гишүүнээр тасаллаа. Ж.Баярмаа гишүүнийг нэмье. Д.Үүрийнтуяа гишүүн үгээ хэлнэ үү.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Хуулийн төсөл дээр гол үзэл санаа бол ерөөсөө санаачлагчдын хувьд барьсан асуудал дээр хоол унд тэр хөнгөлөлттэй, унаа, түлшний хөнгөлөлт дээр шимтгэл тооцох, тооцохгүй асуудал дээр л байгаа шүү дээ.

Бусад үзэл санааны хувьд ерөнхийдөө яамны бодлоготой уялдаад нийцээд явж байгаа юм байна гэдэг ийм дүр зураг харагдаад байгаа юм.

Тэгээд өнгөрсөн долоо хоногт санагдаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс нийгмийн даатгалын тогтолцооны, нийгмийн хамгааллын үндэсний тогтолцоог бүрдүүлэх үүднээс цогц системээр нь шинжилгээ хийж, судалгаа хийгээд, үүн дээрээ 7 багц хуулийг өргөн барина гээд танилцуулга, мэдээллүүдийг хийсэн.

Энэ дотор нийгмийн даатгалын ерөнхий хуулийн өөрчлөлт, тэтгэврийн реформ дээр суурилсан, тэтгэврийн даатгалын реформ дээр суурилсан өөрчлөлт явж байгаа юм билээ. Үүнтэй ажлын хэсгийн энэ оруулж байгаа саналыг аваад үзэхээр ерөөсөө л саяын яриад байгаа хоол, унаа, түлээ түлшний хөнгөлөлт. Энэ дээр яах вэ л гэдэг асуудал.

Тэгээд үүнийг магадгүй нөгөө үндсэн цалингийн тэдэн хувиас хэтрэхгүй байх гэдэг хязгаар тогтоож өгөөд, түүний үр нөлөө ямар байх вэ гэдэг тооцооллоо хийгээд явах юм бол нэг их нийцэхгүй маргалдаад байх асуудал харьцангуй гайгүй болов уу гэж бодож байгаа юм.

Яамнаас хүсэх нэг хүсэлт байна. Л.Мөнхзул дарга гараад явчихлаа. Түрүүн Л.Мөнхзул дарга хариултдаа хэлсэн. Яагаад хууль дээр татгалзсан санал өгсөн юм бэ, дэмжихгүй санал өгсөн юм бэ гэж.

Хоёр үндэслэл хэлж байна лээ.

Нэгдүгээрт, тэр тооцооллын асуудал дээр нягтлах нь зүйтэй байх.

Хоёрдугаарт, төсвийн жилд төсөвт өөрчлөлт оруулах асуудлыг дэмжихгүй гэж. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд чинь яаж ажлаа хийх юм бэ, тэгэхээр.

Хэрвээ хууль санаачлаад тухайн хууль нь төсөвтэй холбоотой асуудал байгаа бол хэрэгжиж эхлэх хугацааг нь дараа жилийн дараагийн төсвийн жилээс гээд заалт оруулаад өгчхөж болно шүү дээ.

Дэмжээд түүнд нь тийм саналаа оруулаад явж болдоггүй юм уу. Яах вэ, Засгийн газар дэмжихгүй байлаа гээд гишүүд хуулиа өргөн барих л байх л даа. Гэхдээ энэ гадна талдаа юу гэж ойлгогдох вэ гэхээр гишүүд нэг юм санаачлаад бүр ямар ч бодлоготой нийцээгүй зөрчилдсөн юм аваачаад санаачлаад оруулсан юм шиг. Тэрийг нь салбарын яам дэмжихгүй байхад парламент дэмжээд гаргаж байгаа юм шиг энэ хоёр институцийн хооронд үл ойлголцол үүсэх түвшинд аваачаад байна.

Ялангуяа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу орсон гишүүдийн санаачилсан хэд хэдэн хуулийн төсөл дээр Засгийн газар дэмжихгүй гэдэг байр суурийг танайх гаргаж өгсөн.

Тэгээд ядаж энэ хууль санаачлаад явж байгаа гишүүдтэй Засгийн газрын хуралдаанаар оруулахын өмнө. Энэ чинь 30 хоногийн дараа та нар хариу өгч байгаа шүү дээ. Ядаж санаачлагчтай нь нэг уулздаг л баймаар байгаа юм. Хуралдаанаар хэлэлцүүлэх гэж байна шүү. Санаачлагчийн хувьд бид яам хууль санаачлагч хоёрын хооронд ийм үл нийцэх шалтгаан байгаа учраас, ийм шаардлага байгаа учраас бид дэмжихгүй санал өгөх гээд байна шүү гэдэг юмаа ярьдаг баймаар байгаа юм л даа.

Бид нарын ажлын уялдаа холбоо байхгүй. Хоорондоо бичиг шидээд суугаад байгаа. Тэгээд уг нь гишүүд хөөрхий тэгээд энд чинь яах вэ гэхээр нэг ажлын хэсэг ахлаад хуулийн төсөл боловсруулаад ордог. Яг үнэндээ Улсын Их Хурлын гишүүд ямар орон тоотойг та хэд бас мэдэж л байгаа байх. Тийм ээ. Тойрог дээр орон нутагтаа ганц зөвлөхтэй. Жагсаалтын гишүүд бол бүр бие төлөөлөгч байхгүй. Тэгээд л эндээ нэг туслах, зөвлөх хоёр л байдаг юм шүү дээ.

Яам бол бүхэл бүтэн аппарат ажиллаж байгаа шүү дээ. Бид хуулийн төсөл өргөн барих гэж энэ цаг хугацаанд үнэхээр ачаалал хүрэлцэхгүй, хүн хүч хүрэлцэхгүй, боломж нөөцөө ашиглаад л Нэгдсэн Үндэстний Байгууллагын хэдэн агентууд, олон улсын байгууллагуудаас тусламж дэмжлэг гуйгаад л, Их Хурлын Тамгын газрын хэдэн ажилтнуудыг цаг нар нь яаж байна гээд л цаг завьг нь харж дуудаад л, гуйгаад л ингээд л сууж байгаа хүмүүс. Яг үнэндээ.

Гэтэл яам энэ бүхэл бүтэн аппарат асуудал хариуцсан хүмүүс байж байж яагаад энэ гишүүдэд та нар нэг ирээд уулзаадах гээд хэлж болдоггүй юм. Бид заавал та нарыг дуудахгүй шүү дээ. Явж очоод л уулзчихна. Тэгээд энэ тал дээрээ бас цаашдаа анхаараарай гэдгийг хэлэх гэсэн юм.

Тэгээд миний хувьд энэ хууль... /минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. Б.Түвшин гишүүн үгээ хэлнэ үү.

Б.Түвшин: Үндсэндээ хоёр зүйлийг л тодорхойлон ярилаа.

Өнөөдрийн байдлаар Нийгмийн даатгалын сан маань 1.4 их наядын шилжүүлэг авахаар байна. Сангийн алдагдал яг одоо байж байгаагаараа 700 орчим тэрбум төгрөг болохоор байна гэж байгаа юм.

Энэ бол ямар ч хуулийн өөрчлөлт ороогүй. Яг одоо байж байгаа байдал. Яг энэ сан талдаа ийм байгаа.

Нөгөө нийгэм талдаа, ажил олгогч талдаа бүх төрлийн орлогоос нь нийгмийн даатгалыг хуу хамдаг болсон. Хувиараа хөдөлмөр эрхэлсэн ч нийгмийн даатгалыг хоёр талаас нь авдаг болсон.

Одоо тэр юу гэж нэрлэх нь үл хамаараад Иргэний хуулийн бүх зохицуулалтуудаас авдаг болсон. Тайлбар нь яаж байна вэ гэхээр Хөдөлмөрийн хуулийг тэгж гуйвуул зугтаах гээд байна гэдэг. Одоо тэр зугтаалгахгүйн тулд бүх бизнесийн орлогоо нуудаг болсон.

Монгол хүн монгол нэрээрээ ямар нэгэн байгууллагатай гэрээ хийхэд орлогоос нь 20 хувь авдаг. Өнөөдөр дэлхийд 40 хувийн татвар төлчхөөд амьд үлддэг ямар ч орлого байхгүй.

Тэгэхээр юу чухал вэ гэхээр бизнесийн орлогыг нь “бизнесийн орлого” гэж хамгаалах нь чухал байна.

Тийм учраас иргэний хуулиар зохицуулж байгаа бизнесийн орлогоос нийгмийн даатгалыг авахгүй болгоод зохицуулчихъя. Үнэхээр хөдөлмөрийн хуулиас нь зугтаах гээд байдаг бол тэр хаалтыг нь хийгээд өгчихсөн нэгдүгээр зохицуулалт байж байгаа.

Хоёрдугаар асуудал. Агуулга, хэлбэр хоёр зөрчилдөөд байгаа байхгүй юу. Унааны мөнгө гэдэг чинь яг юу юм. Хоолны мөнгө гэдэг чинь тэр хүнд нь хоолыг нь өгөх гэж байтал дундаас нь нийгмийн даатгал авчихъя гээд байдаг. Энэ агуулга, хэлбэр хоёрын зөрүү шүү дээ.

Бид ерөөсөө энэ агуулга руугаа явахаа байсан. Хэлбэр болсон. Унаа, хоолны мөнгөө оруулаад тооцчихдог. Одоо тэрийг нь бууруулахаар Нийгмийн даатгалын сан нь буурах гээд байна гээд байгаа. Үгүй тэгээд хоол идэхийн тулд нийгмийн даатгал зөв юм уу. Хоол, унаанд чинь бид хуульдаа юу гээд заасан бэ гэхээр тэр хөдөлмөрийн хууль дээр цалин хөлсөнд нь оруулаагүй. Тэгээд ажилтны өдөр тутмын наад захын хэрэгцээ, амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, тэдэнд тулгарч буй нийгмийн эрсдэл, санхүүгийн ачааллыг бууруулах зорилготой мөнгө л гэж тодорхойлсон шүү дээ.

Тэгээд энэ тодорхойлолтоос нь дахиад нийгмийн даатгал аваад. Тэр нь тэтгэвэрт нь нөлөөлнө гэж айлгаад байгаа нь зөв юм уу.

Тэгэхээр энэ үнэн үг гэдэг нь хаана байгаа юм. Үнэн ер нь хаана байгаа юм. Хоол, унаанаас нийгмийн даатгал авахаа больчихоор тэтгэврийн сан алдагдалд орох гээд байгаа бол энэ төлж байгаа хүмүүс чинь өнөөдөр ирээдүйд бүр юу ч авахгүй л гэсэн үг шүү дээ.

Одоо төлж байгаа дээрээ юм авахгүй ирээдүй нь буурах гээд байгаа юм бол одоо сан чинь хоосорсон байгаа шүү дээ.

Дахиад бид тэжээгчээ устгана гэдэг шиг энэ өндөр ачаалал өндрөөрөө байгаад байвал дахиад бүгд сүүлдээ ерөөсөө ажилгүйдэл болох гэж байна шүү дээ. Бизнесийн байгууллагууд чинь ч дампуурах гэж байна. Ерөөсөө хувь хүмүүс

нь ч орлогогүй болж ядуурч эхэлж байна. Бараг маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг болсон байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ агуулга руу нь зөв болгоё оо, хэдүүлээ. Нийгмийн даатгалыг хэнээс авдаг болох вэ гэхээр “цалин хөлс” гэдэг тодорхойлолтоос авдаг болъё. Одоо энэ буурах гээд байгаа том эрсдэлийг ямар нэгэн шийдэл болоод зохицуулъя.

Хамгийн муухайгаар зүгээр тэндээс нь авдаг болоод Нийгмийн даатгалын сан буурахгүй гэдэг чинь энэ нийгмийн даатгалын тэтгэвэрт гарах гэж байгаа яг одоогийн ойрын хэдэн жил гарах гэж байгаа хүмүүст л нөлөөлж магадгүй болохоос биш ер нь бол цаашдаа энэ ид төлж явж байгаа хүмүүст бас хамааралгүй зүйл. Эдийн засгийн хохиролтой зүйл.

Тэгээд үүний шийдлийг одоо хэдүүлээ агуулгын хувьд зөв олъё гэж бодож байна.

Дээрээс нь энэ Их Хурлын гишүүд хууль санаачлах нь ямар нэгэн Засгийн газрын бодлоготой нийцэж байж явдаг гэдгийг болимоор байна. 01 сарын 02-нд 41 гишүүн санаачлаад энэ хуулийнхаа төслийг боловсруулсан. Тэгээд одоо нийцэж байгаа хоёрыг нь явуулъя, нийцэхгүй нэг нь байна гэж. Яриад зөвшилцөж ч болно шүү дээ. Энэ асуудлыг чинь одоо тэгээд хэн санаачлах ёстой юм.

Энэ хуулийн төслийг бид тавиад, олон нийтэд хэлэлцүүлэг хийгээд явж байгаа. Энэ бүх статистик тооцооллуудыг одоо байгаагаас нь бууруулахгүйгээр тооцоо хийсэн. Хэн ч гэсэн гаднаас ийм хэлбэртэй, муу хэлбэртэй гээд тооцоо хийгээд байж болно шүү дээ.

Тийм учраас ойлголцож болно. Хууль тогтоомжийн хувьд ч гэсэн хамтад нь хэлэлцэх боломж бас байгаа. Үүнийг хэлэлцэх асуудлыг нь Та бүхнийг... /минут дуусав/

Л.Энхнасан: Баярлалаа. О.Саранчулуун гишүүн үгээ хэлнэ үү.

О.Саранчулуун: Би дахиад л буцаад л нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ асуудлаар өөрийн байр сууриа хэлэхгүй бол ерөөсөө болохгүй байгаа.

Одоо бид гэртээ засвар хийчихье гэхээр хэсэгчлээд л засаад байна шүү дээ. Тийм ээ. Одоо эхлээд л нэг өрөөгөө, нэг өрөөгөө гэдэг шиг.

Тэгэхээр том зургаараа орчин маань бүрэн бий болж болохгүй гэдэг шиг би зарчмын хувьд үүнийг ингээд энэ яваасай л гэж бодоод байгаа юм. Зөв. Тэгвэл яам яагаад одоо надад түрүүнээс хойш энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой, бид яг үүнийг

хийх гэж байна, ингэх гэж байна гэдэг мэдээллийг нэг олигтой хариулаад өгчихгүй. Сангийн яам ерөөсөө тоо баримт байхгүй. Энэ ийм байдалтай байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүн өнөөдөр нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлууд байгаад байгаа байхгүй юу. Бага хэмжээний халамж дээрээ гацсан хэвээрээ байна, шилжиж чадахгүй байгаад байна. Дандаа хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолт руу арай гэж шилжиж байна. Тийм ээ. Гэтэл тэр нөгөө дүн нь өсөхгүй шүү дээ.

Тэгэхээр нөгөө л хүн амдаа зориулсан Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа үйлчилгээ, тэр үр ашиг нь хөгжлийн бэрхшээлтэй хүндээ ээлтэй байхтай холбоотойгоор нийлүүлээд энэ яам одоо энэ хуулийн хэсэгтэй хамтраад энэ хуулийг ингэж дэмжээд цаашаа яваасай л гэж бодож байна.

Тэгээд яам оруулна гэхээр ингээд хүлээгээд л байдаг юм байна. Ер нь байгаад л байх юм. Бүх л юм ингээд л нэг ийм удаан процесстой. Энэ нь өөрөө бас аягүй ийм цаг авсан, ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг угаасаа бий болгож байна.

Үүнийг зөвхөн би ч хэлж байгаа юм биш. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн коментууд ирсээр л байгаа. Асуултууд ирсээр л байгаа. 20 жил, тэдэн жил ингэж ажиллаад ингэж шилждэг. Бэрхшээлтэй хүн алга гээд хэлээд байдаг. Тоолоод ч өгөхгүй юм. Хэдэн тоог нь гаргаад ч өгөхгүй. Ерөөсөө. Тэгээд энэ дээрээ ингээд байр сууриа өөрсдөө хүн ам дээр ингэсэн юм шүү гэдгээ хэлэхгүй.

Гэтэл нөгөө талд арай өөр бүлэгт хүн амд зориулж байгаа хуулийн төслийг болохоор дэмжихгүй гээд. Тэгээд одоо яг яая гээд байгаа юм бэ. Би энэ дээр иргэдэд юу гэж хариулах эсэхээ мэдэхгүй л байгаад байна. Нэг ийм ойлгомжтой, хурдхан шиг шийдвэрээ гаргаад, хоорондоо ярилцаад хийчхэж болдоггүй юм уу. Энд чинь өчнөөн олон хүмүүс хүн болгон л жилд хэчнээн мянган хүн тэтгэврийн нас руу шилжиж байдаг байгаа байлгүй дээ. Тэр тоо энэ тэр нь ч байхгүй.

Тэгэхээр энэ дээр би заавал сайжруулсан байдалтай ийм мэдээллүүдийг нэмж заавал авмаар байна.

Л.Энхнасан: Баярлалаа. С.Зулпхар гишүүн үгээ хэлнэ үү.

С.Зулпхар: Б.Түвшин нарын гишүүдийн хууль санаачлах эрх, хууль санаачлах санаачилга, нийгмийн хүлээлтэд нийцсэн байдлаар, нийгмийн эрэлтэд нийцсэн байдлаар, нийгмийн гишүүдийн, нийгмийн тодорхой бүлгүүдийн саналд нийцсэн байдлаар явж байгаа гэдэгт огт эргэлзэхгүй байгаа. Тийм ч байгаа нь сайн байгаа юм.

Энэ хуулийг угаасаа гурван үндсэн заалтаар суурилсан байдлаар нь зохицуулж явах гээд байна шүү дээ. Тэр нь өөрөө нэг асуудлыг нь бид угаасаа байж болох зүйл гэдгийг би хувьдаа дэмжиж байгаа. Тэр хоёр дахь асуудал гэж яриад байгаа шүү дээ. Одоо бидэнд өгсөн энэ хуулийн төсөл юугаар.

Нөгөө хоёр дээр нь нарийн тооцооллууд угаасаа хийгдэж таарна. Хийгдэхгүйгээр бид энэ асуудлыг ямар нэгэн шийдвэр болгож ерөөсөө болохгүй. Тийм шийдвэр гаргачхаад маргааш үүний үр дагаврыг бид өнөөдөр ингээд яг биет байдлаар яг л эдлээд л байж байгаа шүү дээ.

Та бүхэнд жишээ хэлье. Одоо Г.Тэмүүлэн гишүүний санаачилсан тэр Малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль дээр яг тухайн үед төрийн захиргааны төв байгууллага бид эсрэг байр суурьтай, үүнийг дэмжихгүй гэдэг байр сууриа илэрхийлсэн шүү дээ. Тооцооллыг нь.

Тэгээд л тэрийг хууль санаачлагч бүрэн эрхтэй учраас гээд л ороод л батлуулсан байхгүй юу. Өнөөдөр хийгээгүй. Хэрэгжүүлэх боломж байхгүй.

Урьд нь хэрэгжүүлснээс болоод нийгмийн даатгал дээр чинь ямар ачаалал үүссэн, ямар тэгш бус байдал үүссэн гээд үүнийг бүгдийг нь яриад. Гаднын экспертүүдтэй 8 улсын эксперттэй ажилласан шүү дээ. Энэ нийгмийн даатгалын багц хууль дээр.

8 улс нь бол пост социалист улсууд, дандаа. Манайхтай адилхан шилжилт хийсэн улсууд байхгүй юу.

Тэр нь дандаа тэр чиглэлээр мэргэшсэн улсууд байсан учраас бид өөрсдийнхөө сайн туршлагыг, тэдний бас сайн туршлагатай, өөрсдийнхөө сорилтыг тэдний сорилттой уялдуулсан байдлаар тэр хууль яваад ингээд иймэрхүү нөхцөлүүд үүссэн юм.

Гэхдээ бие биеэ үгүйсгэхдээ гол биш. Одоо нэгэнтээ бидэнд нийгмийн эрэлт байгаа бол түүнд тохирсон бид хариулт олох л ёстой. Тэгж байж бид чинь хууль тогтоогч гэж байгаа учраас одоо бас хэдүүлээ бод оо л гэж байгаа юм.

760-аад мянган хүний яг өнөөдөр нийгмийн хамгааллын асуудал байхгүй юу. Нийгмийн даатгалын сангаар дамжиж олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал. Үүнтэй холбоотой эрсдэлийг л ярьж байгаа юм.

Цаашлаад 1.3 сая даатгуулагч байж байгаа юм. Эдгээр улсуудын ойрын хугацааны болон урт хугацааны бас нийгмийн хамгааллын асуудал учраас тооцоо нарийн байх ёстой гэдэг талаас нь бид ярьж байгаа шүү. Түүнээс гишүүдийнхээ энэ санаачилсан хуулийг огт эсэргүүцээгүй. Нэг заалтыг нь би шууд болно гээд л бодож байгаа. Анхнаасаа ч тэгж бодож байсан.

Одоо хоёр зүйл дээр нь түүн дээр ийм тохиргоо хийх юм байна гэж бодож байгаа. Тэрийг тооцоо хийх ёстой байх гэж бодож байгаа юм.

Нийгмийн даатгал дээр Та бүхэн бас зөв ойлголттой байгаарай. Нийгмийн даатгалын сан дампуураагүй. Нийгмийн даатгалын сан ямар нэгэн байдлаар шинэ хуулийн хүрээнд ч бай ажиллаж байгаа. Тэр төрөөс авч байгаа дотаци чинь хуулийн дагуу л авах ёстой улсуудад өгч байгаа дотаци болохоос биш шимтгэл төлөгчтэй холбоотой асуудал ерөөсөө биш.

Тэр битгий хэл одоо жишээ нь шинэ хуулийн хүрээнд энэ нийгмийн даатгалын сангийн менежмент харьцангуй боловсронгуй болоод чөлөөт мөнгөн үлдэгдлийг нь банканд байршуулаад хүүг нь авдаг ажил чинь одоо энэ жилийн 01 сарын 01-нээс л эхэлсэн. Энэ жил 700 тэрбум төгрөг дээр 105 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олно. Энэ бол банканд байршуулсан.

Нөгөөтээгүүр Засгийн газрын 300 тэрбумын бонд худалдаад авчихсан. Эндээс 15 тэрбумын бас орлого орж ирнэ. Ингээд ирэхээр зэрэг менежмент харьцангуй боловсронгуй болж байгаа учраас бас зөв талаас нь зарим зүйлийг бид болж байгаа талаас нь ярья.

Гэхдээ одоо миний хэлэх гэж байгаа санал бол Засгийн газар энэ хуулиа хурдан оруулж ир. Гишүүдийн хэлж байгаа зөв шүү дээ. Бид мэдээж засгаар нэг оруулсан чинь ахиад засаг байгуулагдсан учраас угаасаа тэгдэг юм. Ахиад л буцаад л яамдаасаа саналаа авдаг ийм процесстой. Тэр нь явах юм байна. Гэлээ гэхдээ ойрын хугацаанд оруулж ирээд.

Засгийн газрын өргөн барьсан хууль чинь их тийм HOLISTIC буюу бүхэлд нь асуудлуудыг харсан. Зарим зүйлүүд нь байгаа юм. Үүний зарим заалтууд ч гэсэн байж байгаа. Ингэж хэдүүлээ хэлэлцэх юм бол зөв байх.

Тэгэхээр Засгийн газар бас ажлаа, ялангуяа яам энэ дээр анхааралтай, хариуцлагатай байж, шуурхай оруулж ирэх ёстой. Шинэ сайдад үүнийг бид Их Хурлаас чиглэл болгодог, даалгавар болгодог юмаа л хийе гэж бодож байна.

Бүхэлд нь гишүүдийнхээ санаачилгыг би дэмжиж байгаа юм.

Л.Энхнасан: Баярлалаа. Ж.Баясгалан гишүүн үгээ хэлнэ үү.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд энэ хуулийг бас санаачилсан хүмүүсийн нэг учраас ажлын хэсгийнхэндээ богинохон хугацаанд маш үр дүнтэй сайн ажилласан гэдгийг энд хэлэх ёстой байх. Үнэхээр яг бүх тооцоо судалгааг хийсэн.

Гэхдээ бид энэ хуулийг яг өнөөдөр шийдэх гээгүй байна. Хэлэлцэх эсэх асуудлыг ярьж байна. Тэгээд мэдээж ямар нэгэн юм хийхэд алдаа оноо байж

таараа. Үүнийг гол нь ил гаргаж, олуулаа хэлэлцэж, буруугүй болгож, алдаа мэдгээ засаж, тооцооллоо зөв хийх нь чухал.

Тэгэхээр сая гишүүдийн хэлсэн саналыг бид хүлээж авч байна.

Нөгөө талдаа тэр тэтгэвэр, тэтгэмжийн асуудалтай ирээдүйтэй холбоотой бас юм ярьж байгаа. Мэдээж энэ дээр дахиад бид тооцооллоо хийх, яамтай ч гэсэн зөвшилцөх тийм боломж байгаа.

Нөгөө бас дахиад нэг талыг нь хэлэхэд яам бол дэндүү хойрго байна. Маш удаан байна. Гишүүд ингээд маш хурдан юмаа хийгээд ороод ирж байна. Яам энэ дээр хурдхан ажиллаад уг нь мэргэжлийн яам учраас энэ дээрээ түлхүү түрүүлээд уг нь дуугараад явчихвал илүү хэрэгтэй байгаа.

Тэгэхээр нэг тоон дээр л хоёр тал болоод л маргалдаад байх ерөөсөө шаардлага алга. Нийгэмд хүлээлттэй байгаа юу, хүлээлттэй байгаа. Яагаад гэвэл хууль өөрөө иргэдийнхээ талд үйлчлэх ёстой учраас. Хууль өөрөө иргэдийнхээ нуруун дээрх ачааг хөнгөлөх ёстой учраас. Хууль өөрөө бүгдэд нь тэгш эрхтэй үйлчлэх ёстой учраас. Энэ утгаараа энэ цаашаа явах ёстой.

Тэгээд одоо хэлэлцүүлгийн явцад гишүүдийн гаргасан санал дээр, тооцоо, судалгаан дээр дахиад ажиллах 100 хувь боломжтой шүү.

Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг энд бас дахиад яамны зүгээс маш тодорхой гаргаж өгөх хэрэгтэй байна. Яам бол хэзээ ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал дээр яг тодорхой гардаггүй. Ерөнхийдөө л бид яриад байдаг. Бид олон удаа уулзаж байгаа. Олон удаа ярилцаж байгаа. Тоо баримт ярихаар дандаа ерөнхий ярьдаг.

Тэгэхээр энэ дээр ерөөсөө яам яг нэг чигтэй, нэг зүгтэй, нэг тоотой болмоор байна. Тэгээд яг ямар учраас тэр түрүүчийн зөрчил үүсээд байгаа юм гэдгээ сайн гаргаж ирэх хэрэгтэй байна.

Аль нь ч оруулж ирсэн. Бид санаачилсан энэ гишүүдийн хувьд хэрвээ яам үнэхээр өөрсдөө түрээд дэмжээд явах юм бол бид дэмжээд л явна шүү дээ. Ялгаа байхгүй. Энэ хууль л хэрэгтэй болохоос хэн санаачилсан, хэн оруулж ирэх нь тийм чухал биш. Энэ хууль өнөөдөр хэрэгтэй байгаа юу гэвэл хэрэгтэй байгаа. Ингээд бүгдэд нь амжилт хүсье.

Л.Энхнасан: Баярлалаа. Х.Болормаа гишүүн үгээ хэлнэ үү.

Х.Болормаа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Манай Байнгын хорооны гишүүд бүгд энэ хуулийг дэмжиж байгаад баяртай байна.

Тэгэхээр сая ихэнх Их Хурлын гишүүд маань хэлчихлээ. Үнэхээр яам бол бас асуусан асуултад хангалтгүй хариулт, мэдээ мэдээллүүдийг их өгч байгаа нь харагдаж байна.

Тэгэхээр өнөөдрийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн орлого муудсан, инфляц өссөн ийм үед нийгмийн даатгалын шимтгэл төлөгч болон ажил олгогч нарын нуруун дээрх ачааг бага ч гэсэн багасгах үүднээс тус хуульд зохих өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж миний хувьд үзэж одоо энэ хуулийн төсөл санаачлагчид гарын үсэг зурж өргөн мэдүүлсэн байгаа.

Мэдээж ойлгомжтой. Энэхүү хуулийн төсөл батлагдвал мэдээж Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрт тодорхой хэмжээний эрсдэл үүснэ. Тэгэхдээ бид эрсдэл үүснэ гээд нийгэмд тулгамдаж байгаа, энэ аж ахуйн нэгжүүдийн нуруун дээр үүрэгдэж байгаа энэ том асуудлыг орхигдуулж болохгүй.

Энэ эрсдэлийг өөр арга хэлбэрүүдээр нөхөх боломжууд маш их байгаа. Жишээлбэл, сайн дурын даатгуулагч нарын тоог нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй албан бус хөдөлмөр эрхлэгч, бизнес эрхлэгч нарыг даатгалд хамруулах. Мөн гадаад улсад ажиллаж амьдарч байгаа, хөдөлмөрлөж байгаа иргэдийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх иргэдийн итгэлийг сэргээх, энэ тогтолцоог ил тод, нээлттэй болгох, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг банкнуудад байршуулаад авч чадахгүй байгаа төлбөрийг барагдуулах. Мөн цаашлаад Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг арилжааны банкуудад хүүтэй хадгалуулах зэрэг олон аргууд байгаа.

Ингэж байж одоо энэ шударга тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Мөн Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтцэд анализ хийх нь хамгийн чухал байна.

Анализ хийгээд, энэ төрлийн халамж зардал илүү дарамт үүсгэж байгаа тэр шалтгаан, үр дагавар багасгах асуудлыг бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ийм шаардлагатай байна. Жишээ нь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал нь нийт зарлагын багагүй хувийг эзэлж байгаа. Тэгвэл энэ төрлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг бууруулах тал дээр ажиллах ёстой гээд. Гэх мэтчилэн олон ажлуудыг зохион байгуулж болохоор байна.

Ингээд манай гишүүд энэ хуулийн төслийг дэмжиж өгөхийг Та бүгдээсээ хүсэж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ө.Шижир гишүүн үгээ хэлнэ үү.

Ө.Шижир: Юуны өмнө эхлээд би Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга руу 03 сарын 30-ны өдөр явуулсан албан бичиг хугацаа хэтэрч ирсэн.

Тэгэхээр төрийн байгууллагууд хуулийн хугацаанд албан бичгийн хариуг явуулдаг байх нэгдүгээрт хэрэг байна.

Хоёрдугаарт, манай төрийн байгууллагууд одоо байгаа байдалдаа сэтгэл ханасан, өөрчлөлтөд дургүй, шинэчлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй, яг өнөөдрөөрөө байх нь өөрсдөд нь илүү тавтай тухтай болсон.

Тийм учраас даа ялангуяа Засгийн газрын харьяа байгууллагууд Улсын Их Хурлын гишүүдийн Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсгүүдийн гаргасан хуулийн төслүүд дээр Засгийн газрын байр суурийг илүү хамгаалж ярьдаг болсон.

Хууль тогтоох байгууллага чинь Улсын Их Хурал. Засгийн газрын харьяа байгууллагууд хууль тогтоох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ёстой. Түүнээс тэрийг үгүйсгээд эсрэг байр суурь илэрхийлээд байж нэгдүгээрт болохгүй.

Хоёрдугаарт, би түрүүн бизнес эрхлэгчтэй холбоотой юм хэлсэн. Төрийн байгууллагууд иргэддээ үйлчлэх гэдэг ёстой бол ганцхан заалт биш шүү. Та нар Монголд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд, бизнесийн байгууллагууд, хувийн хэвшил, бүх ямарваа нэгэн өмчийн хэлбэр үл хамаараад тэр бүгдэд үйлчилдэг, тэд нарт ажилладаг байх ёстой.

Бизнесийн байгууллагынхаа татваруудыг хуу хамчхаад, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажил олгогчийнхоо татварыг хуу хамчхаад тэдэнд өнөөдөр өсөж дэвжих, хөгжих ямар ч боломжийг нь олгохгүй байж дандаа сөрөг коммент хэлээд байдаг байж бас болохгүй.

Би нэг жишээ хэлье. 2021 онд 205 мянга байсан төрийн албан хаагч өнөөдөр 226 мянга 895 болоод 9.8 буюу 10 хувиар өссөн. Төрийн албан хаагч нар.

Хувийн хэвшил буюу аж ахуйн нэгжид ажилладаг албан хаагч нар чүү ай 8.9 хувиар өссөн. Зөв тогтолцоотой, зөв бизнесийн орчинтой, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн орчин зөв байсан бол хувийн хэвшлийнх нь нэмэгдэх хувь нэмэх олон байхгүй юу. Илүү байх ёстой юм.

Та нар ер нь орон зайгаа нэмж өгөхгүй байгаа юм. Болж байгаа бүтэж байгаа бүх юмнаас нь, данс руу нь орсон бүх орлогоос нь бүх татварыг нь авчхаж байгаа юм. Одоо бүр амар болсон. Авахгүй бол хаадаг болсон. Дансыг нь.

Тэгэхээр бид энэ юмнууд дээр их сайн анхаарах хэрэгтэй. Ажил олгогч байхгүй болбол хэн нийгмийн даатгалын шимтгэлийг чинь төлж, хэн та нарын наад санг чинь бүрдүүлэх юм.

Тийм болохоор төрийн бүх байгууллагууд ажил олгогч талдаа илүү анхаарч ажиллаж байж бид зах зээлээ тэлнэ. Бид илүү их боломжоо бий болгоно, бизнесийн орчинг илүү их дэмжинэ. Тэгж байж бид нарын энэ одоо тэр 700 тэрбумын алдагдалтай яваад байгаа юм чинь алдагдалгүй болно.

Өнөөдөр байгаа зүйлээ арай өөрөөр хараач ээ. Гадны жишээ судлаач ээ. Жишээ нь, дэлхийн аль ч улсад. Дэлхийн аль ч улсад шүү. Та нар судлаад үзээрэй. Би үүнийг судалгаа хийлгэсэн юм.

Дэлхийн аль ч улсад Иргэний хуулиар зохицуулсан гэрээний дагуу олж байгаа орлогыг Хөдөлмөрийн хуультай адилхан үзээд татвар шимтгэл авдаггүй юм байна. Сангийн яамныхан. Иргэний хуулиар зохицуулсан гэрээний дагуу олж байгаа орлогоос татвар шимтгэл авдаггүй юм байна.

Яагаад гэхээр одоо танай нийгмийн даатгал дээр чинь нийгмийн даатгал төлдөг үндсэн ажил нь 01 кодтой юм байна шүү дээ. Тухайн байгууллагадаа ажиллаж байгаа иргэн цалингаас өөр орлогоор буюу ямар нэгэн давхар ажил эрхлэхэд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хэдийгээр татвар төлж байгаа ч энэ тэтгэвэрт гарах гэрээний үүрэг, хариуцлагад ямар ч нөлөө байхгүй. Жишээ нь.

Тийм болохоор тухайн байгууллагууд давхар ажил эрхэлж байгаа хүнийг хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхлүүлэхдээ тухайн хүний авах цалингаас байгууллагынхаа төлдөг татварыг хасдаг болсон. Энэ чинь байгууллага ч талдаа хохиролтой, иргэн ч талдаа хохиролтой.

Тэгэхээр зах зээлээ бодооч ээ, хувийн хэвшлээ бодооч ээ, татвар төлөгчдөө бодооч ээ, шимтгэл төлдөг хүмүүсээ бодооч ээ. Битгий зөвхөн өөрсдийнх нь санг бодоод байгаач ээ.

Л.Энхнасан: Баярлалаа. Ж.Баярмаа гишүүн үгээ хэлнэ үү. Алга байна уу? С.Эрдэнэбат гишүүн бас хамгийн сүүлд үгээ хэлье гэсэн. Байхгүй байна.

Би бас гишүүний хувьд энэ хуулийг дэмжиж байгаа. Харин хууль хэлэлцэх явцад ингээд дэмжигдэх юм бол ажлын хэсэг гэж засгаас гарсан хуулийн төсөл болон Б.Түвшин гишүүнээс гарч байгаа хуулийн төсөл бол энэ тооцоонуудаа нэгтгэж, тэгээд цаашдаа дэгийн хуулийн дагуу. Гишүүдээс гарсан санал бол дэгийн тухай хуулиар 39.26-гаар нэг асуудлаар хоёр ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийн анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн нэг төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийг хамтаар. Хэрэв энэхүү нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэсний дагуу ингэж нэгдэх юм байна гэж л ойлголоо.

Ингээд гишүүдээ дуудаарай. Гишүүд санал хураалт өгөхдөө бэлдээрэй. Санал хураалтдаа бэлдээрэй. Баярлалаа. Орой болтол сууж байгаа гишүүдээ баярлалаа. Бидний санал хураалтдаа бэлдээрэй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 05 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн санал хураалт явуулъя. /алх цохив/

92.9 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү уншихыг томилъё.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Одоо хоёр дахь асуудал. Ажлын хэсэгт баярлалаа.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батална.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.1.2-т даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан Үйлдвэрчний эвлэлээс 3 хүн гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос төлөөллөө дахин нэр дэвшүүлж байна.

Өмнөх нэр дэвшигч нэрээ татсан тул томилох ажиллагаа дахин эхэлж байгаа.

Та бүхэнд тогтоолын төсөл болон Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос ирүүлсэн албан бичиг, нэр дэвшигч Г.Адъяагийн товч танилцуулга материалыг хүргүүлсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 30.1, 122.1-д заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоож, сонсгол даргалагчийг томилох ёстой.

Даргалагчаар өмнө нь Ц.Идэрбат гишүүн байсан. Одоо бас даргалах саналтай гишүүн байвал хэлж болно. Ц.Идэрбат гишүүн өөрөө татгалзсан.

Тэгэхээр С.Зулпхар гишүүн. Баярлалаа. С.Зулпхар гишүүн даргалахаар томиллоо. Мөн хугацааг дэгийн хуулийн хүрээнд тов товлосноос хойш 14 хоногийн дараа байхаар хамгийн боломжит хугацаа 07 сарын 01 болж байна. Тэгээд 07 сарын 01-ний өдрөөр товллохор тогтооё.

Уучлаарай. Ажлын хэсгээ танилцуулахаа мартсан байна. Ажлын хэсэг М.Нямдаваа Монгол үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга.

Баярлалаа. Энэ орой хүртэл сууж байгаад.

Тогтоолын төслийг уншъя. “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулахаар товлосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарыг томилсугай.

3.Нэр дэвшигчдийн сонсголын талаар нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангах, холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо Л.Энхнасан, мэргэжил арга зүйн техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Б.Баасандорж нарт тус тус даалгасугай.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа. “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт. /алх цохив/

85.7 хувиар дэмжигдлээ.

Ж.Баярмаа гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэнэ үү. 85.7 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 32 минут үргэлжилж, 18 цаг 28 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД